

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах  
эрхийн тухай хуулийн 23, 24 дүгээр  
зүйлийн хэрэгжилт





*Empowered lives.  
Resilient nations.*

“Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” МОН 13/102 төсөл©

Тус судалгааг Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр Глоб Интернэшнл төв, Зориг сан ТББ нар хамтран гүйцэтгэв.

Судалгаанд дурдагдсан дүгнэлт, зөвлөмж нь зохиогчдын байр суурь бөгөөд Монгол Улсын Их хурал ба НҮБХХ-ийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

Энэхүү судалгааны тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

“Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл  
Монгол улс, 14201 Улаанбаатар хот, Төрийн ордон. Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1. Утас: +976-51-263143 [splp.parliament.mn](http://splp.parliament.mn)

2014 он

НЭР ТОМЪЁОНЫ ТОВЧЛОЛ	5
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ	6
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	7
Судалгааны зорилго	7
Судалгааны зорилт	7
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	8
Судалгааны арга	8
Судалгаанд хамрагдсан байдал	9
Судалгааны хугацаа	10
ЭРХ ЗҮЙН ОРЧИН	11
Мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан нь	11
Мэдээллийг цахим хэлбэрээр өгөх	14
Хууль хэрэглээний эрэмбэ ба практик	16
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	18
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт	18
Хуулийн талаарх ерөнхий ойлголт	18
Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэр сайн мэдэх вэ?	18
Мэдээллийн самбар	19
Цахим хуудас	19
Санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр	20
Хандлага	20
ХУУЛИЙН 23, 24 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ	21
Тэмдэглэл хөтлөх	21
Мэдээлэл хариуцсан ажилтантай байх	27
Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих	33
Үр дүнгийн гэрээнд тусгаж, үнэлгээний гол шалгуур болгож буй байдал	34
ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БЭЛТГЭЛТЭЙ БАЙДАЛ	37
Сургалт	37
Мэдээллийн хүртээмжтэй байдал	38
Төсөвтэй байх	39

Мэдээлэл авахаар хүсэлт гаргагчийн төлөх төлбөр	39
Цахим хуудсаар мэдээлэл хүсэх боломж	40
Төрийн байгууллагууд мэдээлэл авах тусгай дугаар	41
<b>ГОМДОЛ ГАРГАХ, ХАРИУЦЛАГА ТООЦОХ МЕХАНИЗМ ҮЙЛЧИЛДЭГ</b>	<b>42</b>
Мэдээлэл өгөөгүй үндэслэлээр хариуцлага тооцсон тохиолдол	43
<b>МЭДЭЭЛЭЛ АВАХ ХҮСЭЛТ БА ХАРИУ ӨГЧ БУЙ БАЙДАЛ</b>	<b>44</b>
Хүндрэл бэрхшээл бэрхшээл	46
<b>ДҮГНЭЛТ</b>	<b>49</b>
<b>ЗӨВЛӨМЖ</b>	<b>50</b>
<b>ХАВСРАЛТУУД</b>	<b>53</b>

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 23, 24-р зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр УИХ-ын тамгын газраас хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб интернэшнл төв”, “Зориг сан” төрийн бус байгууллага хамтран бэлтгэв.

Мониторингийн багийн ахлагч:

Дашийн Мөнхбүрэн,  
“Глоб Интернэшнл Төв” ТББ-ын хуульч, магистр

Арга зүйн зөвлөгөө өгсөн:

Хашхүүгийн Наранжаргал,  
“Глоб Интернэшнл Төв” ТББ-ын тэргүүн

Зөвлөх:

Дамдинжавын Баярцэнгэл,  
“Зориг сан” ТББ-ын хөтөлбөрийн зохицуулагч,  
магистр

Судлаач:

Дашзэвэгийн Амарсайхан,  
“Глоб Интернэшнл Төв” ТББ-ын судлаач  
Батчулууны Гэрэлмаа,  
“Зориг сан” ТББ-ын хөтөлбөрийн зохицуулагч,  
магистр

Багт ажилласан:

Мөнхсаруул  
Энхбаяр  
Ундрах  
Гансүх  
Энхжаргал

Тайланд ашиглагдаж буй ойлголт, нэр томъёо нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” -д зааснаар тайлбарлагдана.

<b>МУ</b>	Монгол Улс
<b>МУОНР</b>	Монголын Үндэсний олон нийтийн радио
<b>МУОНТ</b>	Монголын Үндэсний олон нийтийн телевиз
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ТАХ</b>	Төрийн албан хаагч
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ХМХ</b>	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>МИТБМАЭ</b>	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх

Ардчилсан төр засаг нь ардчилсан нийгмийн эрхэм үнэт зүйлс болох эрх чөлөө, тэгш эрхийг иргэддээ олгохыг гол тулгуур механизм болгодог. Энэхүү механизмын хөдөлгөгч хүчний салшгүй нэг хэсэг бол төрийн байгууллагын нээлттэй ил тод байдал юм.

“Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд ... НҮБ-аас тунхагласан бусад эрх, эрх чөлөөг хэмжих үндсэн хэмжүүр мөн” хэмээн 1948 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн анхдугаар чуулга уулзалтын 59 дүгээр тогтоолд тунхаглажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэйг тунхагласан. Мөн Монгол Улс нь 1961 онд НҮБ-ын гишүүн орон болж, Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад 1974 онд нэгдэн орсон. Эдгээр бичиг баримтын 19 дүгээр зүйлд “төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр, түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хүлээн авах, түгээх эрхтэй” гэж мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулснаараа дээрх эрхийг хангах үүргийг олон улсын өмнө хүлээсэн билээ.

2002 онд Глоб Интернэшнл төв ТББ-аас олон улсын 19-р зүйл (ARTICLE 19) байгууллагатай хамтран хийсэн “Шилжилтийн үеийн Монгол Улсын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиуд” тайланд “Монгол Улсын төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй байдал хангалтгүй байгаа нь гол бэрхшээл юм” гэж дүгнэсэн байдаг.

Авлигын эсрэг хуулийг 2006 онд, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд баталсан нь дээрх Үндсэн хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх, мэдээллийг нээлттэй, ил тод болгох эрх зүйн суурь бүрэн тавигдсан.

МИТБМАЭ-ийн тухай хуульд уг хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудаас мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг, хүсэлтэд хариу өгөх, хянан шийдвэрлэх хугацаа, давж заалдах, хариуцлага хүлээлгэх зэргийг тусгайлан заасан. Хэдийгээр төрийн байгууллагуудын хувьд мэдээллийг нийтэд ил тод байлгах үйл ажиллагаа сайжирч байгаа ч, МИТБМАЭ-ийн талаарх олон нийтийн мэдлэгийн түвшин, хэрэгжилт болон эрэлтэд тулгуурласан хэрэглээ төрийн байгууллагуудын дунд харилцан адилгүй байгаа ба авлигын түвшин болон төр засгийн хаалттай байдал иргэдийн сэтгэлийг зовниулж байна. МИТБМАЭ-ийн тухай хуулийн хүрээнд судалгааг Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Азийн сан болон IRIM байгууллагууд төрийн байгууллагын мэдээллээ цахим болон мэдээллийн самбараар ил тод болгож буй ерөнхий төлөв

байдлын талаар зарим нэг судалгаа хийж, тэдний судалгаанд орон нутгийн оролцоо маш бага байв. Судалгааны дүнгээс үзэхэд иргэдийн 9.5% нь МИТБМАЭ-ийн талаар мэдээлэлтэй байв. Гэвч энэхүү судалгаанд хуулийн хэрэгжилтийн талаар тодорхой мэдээлэл байдаггүй.

Глоб Интернэшнл Төв ТББ, Авлигатай тэмцэх газар, Ил тод байдал сан зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд тус хууль батлагдснаас хойш дор бүрнээ судалгаа, үнэлгээг хийж, сургалт явуулж, зөвлөмж хүргүүлж ирсэн. Үүний үр дүнд хуульд заасан дөрвөн төрлийн мэдээллийг ил тод болгох ажилд ахиц гарч, хуулийн талаарх төрийн албан хаагчдын мэдлэг ойлголт ч нэмэгдэж байгаа.

Гэвч өнөөдрийг хүртэлх хийгдсэн үнэлгээ судалгааны ажил нь хуулийн талаарх мэдлэг, ойлголт, хуулиар заасан дөрвөн төрлийн мэдээллийг ил тод болгож байгаа арга, хэлбэр, сурталчилгаа зэрэгт хэт төвлөрсөн.

МИТМАЭ-ийн тухай хуулийн хэрэгжилт болон хэрэгжилтэд саад болж буй гол хүчин зүйлүүдийг судалсан иж бүрэн судалгаа байхгүй байна.

Тухайлбал иргэн, хуулийн этгээдийн зүгээс төрийн байгууллагаас мэдээлэл авах, тэдэнд мэдээлэл өгөх, тэмдэглэл хөтлөх, мэдээллийн үнэ, төлбөр, мэдээлэл өгөхтэй холбоотой гарах зардал зэрэг асуудал тусгайлан судлагдаагүй.

Иймд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлийн хэрэгжилтийг судлах нь тус хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнуудын хариуцлагатай байдал, ойлголт, хэрэглэж буй стандартын талаар тодорхой мэдээлэлтэй болсноор түүнд хяналт тавих, иргэдийн ашиглаж сурах, иргэдийн мэдээлэлтэй байх эрх бүрэн хангагдахад чухал ач холбогдолтой юм.



## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

### СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 23, 24 дүгээр зүйлийн хэрэгжилтийн байдлыг тандан судалж, иргэн хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авч байгаа зураглал гарган, цаашид мэдээлэл өгөхтэй холбоотой бүтэц, зохион байгуулалт, арга, хэлбэрийг сайжруулах талаар зөвлөмж боловсруулахад оршино.

### СУДАЛГААНЫ ЗОРИЛТ:

- Хуулийн 23 дугаар зүйлийн хэрэгжилт буюу тэмдэглэл хөтөлж буй практикийг судлах
- Хуулийн 24 дүгээр зүйлийн хэрэгжилт, үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар хэрхэн тусгасан, үнэлгээний гол шалгуур үзүүлэлт болгож буй байдлыг үнэлэх
- Хуулийн дээрх заалтууд хэрэгжих боломж нөхцөл буюу төсөв, хүний нөөц, зохион байгуулалт, сургалт, бусад шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхийг тодорхойлох.
- Давж заалдах, хариуцлага тооцох механизм үр дүнтэй эсэх

Хуулийн 23, 24 дүгээр зүйл нь мэдээлэл хүсэгчийн идэвхтэй үйлдлээр хэрэгжих боломжтой төдийгүй, түүнийг хэрэгжүүлэхийн тулд байгууллага, албан тушаалтнууд хүсэлтийг хүлээн авах, тэмдэглэл хөтлөх, тэр даруй хүсэлтэд хариу өгөхөд бэлтгэлтэй, мэдээлэл цэгцтэй, системчлэгдсэн байхаар зохион байгуулалтыг хангасан байх, түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх үйл ажиллагааны зарчмаа баримтлах, хуулийг иргэдэд сурталчлах зэрэг талуудын оролцоо, хяналт, эргэх холбоог бий болгосноор хууль бүрэн утгаараа хэрэгжиж, мэдэх эрхийг хангах боломж бүрдэнэ гэж үзэв.

### СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны арга зүйг боловсруулахдаа тоон болон чанарын аргыг хослуулан ашиглав.

#### ▶ Анкетын арга

Зорилтод болон бусад байгууллагаас мэдээлэл цуглуулах зорилгоор хоёр төрлийн анкет боловсруулсан. Нэг нь судалгааны багийн очиж ажиллаагүй 19 аймгийн ЗДТГ, ИТХ, Халамж үйлчилгээ, газрын асуудал эрхэлсэн хэлтсүүдэд Авлигатай тэмцэх газраар дамжуулан хүргүүлж, судалгааны үндсэн мэдээллийг цуглуулсан. Нөгөөг нь судлаачид зорилтод аймгийн төрийн байгууллага, агентлаг руу биечлэн очиж мэдээлэл цуглуулав.

#### ▶ Ярилцлагын арга

Сонгон авсан хоёр аймаг, хоёр дүүрэг, нийслэлийн болон засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн удирдлага, албан хаагч нийт 57 хүнтэй ярилцлага хийсэн. Үүнд: Улаанбаатар хотод БЗД, СХД, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 27 хүнтэй, орон нутагт Төв, Дундговь аймгийн ЗДТГ, ИТХ, Газрын алба, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 30 хүнтэй уулзаж, ярилцав.

Албан хаагчдын МИТБМАЭ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдлэг, мөн тухайн мэдээлэл хүсч ирсэн иргэн, хуулийн этгээдтэй хэрхэн харилцдаг, мэдээлэл өгөх эрмэлзэл, хандлага, хууль хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, түүнийг хэрхэн даван туулахтай холбоотой асуултуудаар хуулийн өнөөгийн хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар ярилцав.

#### ▶ Ажиглалтын арга

Мэдээлэл ирүүлсэн 20 аймаг болон хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан байгууллагуудын цахим хуудсанд хандах замаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн ерөнхий байдалд ажиглалт хийв. Төв аймаг, Дундговь аймагт, БЗД, СХД-ийн мэдээллийн ил тод байдлыг биечлэн

очиж ажиллах явцдаа мэдээллийн самбарт ажиллалт хийв. Ажиглалтаар хуулийн хэрэгжүүлэхэд бусдаас ялгарах онцлог, сайн тал, туршлагуудыг илүү харсан ба мэдээллийн самбарын шинэчлэлт, мэдээллийн хэрэгцээт байдал, бүрэн байдал зэрэг чанарын талын ажиглалт хийгээгүй болно.

▶ Баримт бичиг судлах арга

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 23, 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн баримт бичгүүд, орон нутгаас анкетын хамтаар ирүүлсэн үр дүнгийн гэрээ, тайлангууд, БЗД, СХД, Төв болон Дундговь аймгаас АТГ ирүүлсэн 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсан дахь тайлан, мэдээ зэргийг судалсан болно.

▶ Кейс судалгааны арга

Мэдээлэл цуглуулах явцад төрийн байгууллагаасаа мэдээлэл хүсээд авч чадаагүй иргэн, хуулийн этгээдтэй уулзах замаар бодит тохиолдлуудыг судалсан.

## СУДАЛГААНЫ ХАМРАГДСАН БАЙДАЛ

Судалгааны анкетыг 20 аймгийн 16 ЗДТГ, 14 ИТХ, 13 Газрын алба, 12 Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ, Газрын алба, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, БЗД-ийн ИТХ болон Халамж үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн өмчийн харилцааны газраас ирүүлсэн болно.


	Аймаг / Дүүрэг / Нийслэл	ЗДТГ	ИТХ	Газрын асуудал эрхэлсэн байгууллага	Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага
1	Архангай	✓	✓		
2	Баянхонгор		✓	✓	✓
3	Баян-Өлгий	✓			
4	Булган	✓	✓		✓
5	Говь-Алтай	✓			✓
6	Говьсүмбэр		✓		
7	Дархан-Уул		✓	✓	✓

8	Дорноговь	✓	✓	✓	✓
9	Дорнод		✓		
10	Дундговь	✓	✓	✓	✓
11	Завхан	✓	✓	✓	✓
12	Орхон	✓	✓	✓	✓
13	Өвөрхангай	✓	✓	✓	✓
14	Өмнөговь	✓	✓	✓	✓
15	Сэлэнгэ	✓	✓		
16	Төв аймаг	✓	✓	✓	✓
17	Увс	✓		✓	
18	Ховд	✓		✓	
19	Хөвсгөл	✓		✓	
20	Хэнтий	✓		✓	✓
Нийт		16	14	13	12

Нийслэл					
21	Баянзүрх дүүрэг				
22	Сонгинохайрхан дүүрэг				
Нийт		18	15	15	14
23	Халамж үйлчилгээний ерөнхий газар				
24	Нийслэлийн өмчийн харилцааны газар				

Судалгааны хугацаанд Сүхбаатар аймгаас бусад нь мэдээллээ судалгааны мэдээлэл боловсруулах хугацаанд ирүүлсэн.

ЗДТГазар мэдээллээ хамгийн сайн ирүүлсэн байна.



### СУДАЛГААНЫ ХУГАЦАА

Судалгааг 2014 оны 11-р сарын 24-ны өдрөөс 12-р сарын 24-ны өдрийг хүртэл нэг сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

### МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛСАН НЬ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу төрийн байгууллага иргэдэд мэдээлэл өгөх, нээлттэй, ил тод байдлыг хангах үүрэг хүлээсэн билээ.

Лондон хот дахь 19-р байгууллага ( ARTICLE 19 ) олон улсын хэм хэмжээ тогтоосон “Олон нийтийн мэдэх эрх: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хууль тогтоомжийн зарчим” боловсруулжээ.

Мөн Монгол Улс нь 1961 онд НҮБ-ын гишүүн орон болж, Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг баталгаажуулсан. Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуульд хамааруулснаас бусад бүхий л мэдээлэл нээлттэй байх ба энэхүү хязгаарлалт нь нарийвчилсан, цаг үеэ олсон байхыг ардчилсан улс орнууд шаарддаг.

Үл хамаарлууд нь маш тодорхой, нарийн тодорхойлогдох ёстой бөгөөд “маш аюултай”, “олон нийтийн ашиг сонирхолд харш” нөхцөлд л хэрэглэнэ.

Аливаа төрийн байгууллага тухайн мэдээлэл нь хязгаарлагдмал тооны үл хамаарлуудын нэг гэж үзсэнээс бусад тохиолдолд мэдээлэл авахыг хүссэн хүсэлтийг биелүүлэх ёстой. Төрийн эрх барих байгууллага 3 хэсэгт сорилын шаардлагыг хангасныг баталж чадахгүй бол аливаа мэдээллийг өгөхөөс татгалзах эрхгүй.

Гурван хэсэгт сорил

- Уг мэдээлэл хуульд заасан хууль ёсны зорилгод хамаатай байх ёстой
- Мэдээллийг задлах нь дээр дурдсан зорилгод заналхийлж, ихээхэн аюул учруулахаар бол
- Дээрх зорилгод учрах аюул занал нь тухайн мэдээллийг нээлттэй болгох олон нийтийн ашиг сонирхлоос илүү их бол

Засгийн газрууд өөрсдийн гэм буруутай үйлдлийг илрүүлэхгүйн тулд мэдээлэл өгөхөд хаалт, саад хийх явдлыг хэзээ ч хүлээн зөвтгөж болохгүй<sup>2</sup>

---

Лондон 1996, 6 дугаар сар

“Хүн бүр төрийн байгууллагаас мэдээлэл авах, түүний дотор үндэсний аюулгүй байдлын холбогдолтой мэдээлэл авах эрхтэй. Энэ эрхийг засгийн газар хязгаарласан нь хуулиар тогтоосон бөгөөд ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэдгийг нотолж чадахаас бусад тохиолдолд хязгаарлаж үл болно”

Гэвч төрийн нууцтай холбоотой хуулиудаар олон нийтийн ашиг сонирхол, тэдний санаа зовоосон мэдээллийг үндэслэлгүй нууцалж байна. Иргэдэд нээлттэй байх ёстой энгийн мэдээллийг ч төрийн нууцын халхавч дор нууцалж байгаа нь харагдав. Түүнээс хойш дээрх нууцын хуулиудад өөрчлөлт ороогүй хэвээр мөрдөгддөг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд **хууль дээдлэх нь** төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг тунхаглаж, Төрийн албаны тухай хуулийн **4 дүгээр зүйлийн 4.2.2 дахь хэсэгт зааснаар** ил тод байх /4.2.2/, ард түмэнд үйлчлэх нь /4.2.3/ **төрийн албанд баримтлах зарчим** болохыг хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хуульд заасанчлан иргэн, албан тушаалтан, албан хаагч бүр “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх” үүргийг хүлээдэг.

Иргэд үндсэн хуульд заасан эрхээ эдлэхийн тулд 2011 оны энэ хууль батлагдахаас өмнө Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995 он)-ийг баримтлан хүсэлт гаргаж, шийдвэрлүүлж байв.

Авлигын эсрэг хуулийг 2006 онд баталснаар дээрх Үндсэн хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх, мэдээллийг нээлттэй, ил тод болгох заалтууд үйлчилж эхэлсэн. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт “төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах, 6.1.10.төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх; 6.1.11.иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг заалтууд орсон нь цаашид иргэн, хуулийн этгээд мэдээлэл хүртэх эрхийг хангах гол зохицуулалт болж байв.

Авлигатай тэмцэх газар байгуулагдснаас хойш “Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүрээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах” талаар дурдсан 18 зүйл бүхий зөвлөмжийг 2007 оны 04-р сард төрийн байгууллагуудад хүргүүлж, түүний хэрэгжилтийн 2 үе шат бүхий мониторингийг 2007 оны 7-12 дугаар сар дуустал хугацаанд хийсэн нь ил тод, нээлттэй байдлыг хангах,

---

Мэдээллийн эрх чөлөөний хууль эрх зүйн зарчмууд, 1999 он, Article XIX  
Үндэсний аюулгүй байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн хүртээмж,  
Йоханнесбургийн зарчмууд, зарчим 11, 1996 он  
“Иргэний мэдээлэл олж авах боломж нөхцөл” судалгаа, “Глоб Интернэшнл” ТББ, 2006 он

төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлд төрийн байгууллага, албан тушаалтнуудыг анхаарлаа хандуулах анхны системтэй оролдлого байв.

Засгийн газраас 2009 онд “Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт батлах тухай” 143 дугаар тогтоолыг баталж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлсэнээр 4 төрлийн мэдээлэл ил тод, нээлттэй байх ёстой гэсэн ойлголт төрийн албан хаагчдад үүрэг болгосноор мэдээллийг ил тод болгох ойлголт бий болсон байна.

“Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн 1.3 дэх хэсэгт “Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх”, 1.6 дахь хэсэгт “Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх”, 1.7 дахь хэсэгт “Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх”-аар заасан байна.

1995 онд батлагдсан Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэдээс нутгийн захиргааны байгууллагад гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай журам, Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-т зааснаар бичиг баримтыг үндэслэн хөтлөлт, баримт бичгийн эргэлтийн зохион байгуулалт, төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж бичсэн өргөдөл, санал, гомдлыг хянан шийдвэрлэх, хяналт, тайлагнах үйл ажиллагаа явагддаг байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг 2011 оны 6 сарын 16-ны өдөр УИХ баталснаар Үндсэн хуулиар тунхагласан мэдээлэл олж авах эрхийг баталгаатай эдлүүлэх процепурын зохицуулалт бий болсон. Тус хуулийн хүрээнд 2013 оны 2 сарын 16-ны өдөр Засгийн газар 54 дүгээр тогтоолоор “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”, 2013 оны 411 дүгээр тогтоолоор “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг тус тус батлан мөрдүүлж байна.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсэгт “мэдээллээр хангах үйл ажиллагаа шуурхай байх”-аар заасан нь мэдээлэл эмх цэгцтэй, системчлэгдсэн байснаар хүсэлтийг шуурхай шийдвэрлэх боломжтой болж, мэдээлэл “үнэ цэнэтэй” байх нөхцөлийг бүрдүүлнэ.



*Хуулийг агуулгын хувьд авч үзвэл хоёр үндсэн хэсэгтэй байна. Үүнд:*

- 1. Хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах байгууллагууд мэдээллээ ил тод болгох /цахим хуудас, мэдээллийн самбар, тайлан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан болон бусад оновчтой хэлбэрээр/ буюу /4 төрлийн стандарт мэдээллээр мэдээлэл хүсэгчийн идэвхгүй хүлээн авагч байдлаар түгээх/*
- 2. Дээрх байгууллагуудаас иргэн, хуулийн этгээд мэдээлэл хүсэх, түүнд хариу өгөх /мэдээлэл хүсэгчийн идэвхтэй үйлдлээр хэрэгжих хэсэг/*

Тус хуулийн хүрээнд байгууллагуудын ил тод болгож буй стандарт мэдээлэл, иргэн, хуулийн этгээдийн нээлттэй болгохоор хүсч буй хэрэгцээт, ач холбогдол бүхий мэдээлэл хоёрын хооронд зөрүү их байдаг. Энэ зөрүү арилсан, эсвэл энэ хоёр “туйл” харьцангуй ойртсон үед үнэн зөв, бодит, хэрэгцээт мэдээлэл ил тод, нээлттэй, “мэдээллийн эрх чөлөө” хангагдсан гэж үзэж болох юм. Ялангуяа цахим хуудсанд тавигдсан мэдээллийг “албан ёсны” байхаар Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолын 4.2 дахь хэсэгт заасан хэдий ч, интернэтээс ишлэл хийх, баримтжуулж, баталгаажуулах зэрэгт техникийн шийдэл, эрх зүйн зохицуулалтын хувьд бүрэн тодорхой болоогүй байна.

Энэхүү судалгааны ажил нь хуулийн хоёр дахь хэсэг хэрхэн хэрэгжиж буйд чиглэв. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 23 дугаар зүйлд [хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах боломжийг хангах зорилгоор тэмдэглэл хөтлөх](#) үүрэг хүлээлгэсэн.

“Мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч буй албан тушаалтан” /11.2/ гэж хуульд тодорхой бус зааснаас дээрх тэмдэглэлийг хэн хөтлөх, хэрхэн хөтлөх, хянан шийдвэрлэх ажиллагааны процедурыг нарийвчлан зааж өгөөгүй, албан хэрэг хөтлөлтийн зааварт өөрчлөлт оруулаагүйгээс байгууллагын бичиг хэрэг, дотоод ажил хариусан ажилтан гэх мэт өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэж, дамжуулдаг албан хаагч эрхэлж байна. Иргэн, хуулийн этгээдээс ирсэн мэдээлэл хүссэн хүсэлтийг өргөдөл, гомдол, үйлчилгээ авах хүсэлтээс ялгаж бүртгэхгүй байна. Иргэдийн мэдээлэл хүссэн хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг ирсэн бичиг, хариуг явсан бичгийн бүртгэлд тэмдэглэж, хянан шийдвэрлүүлэх ажиллагааг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл заалтыг хэрэглэн, 30 хоногт шийдвэрлэж, мэдээлэл хүсэгчийн эрхийг зөрчигдөхөд хүргэж байна.

Хуулийн 24 дүгээр зүйлд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуурын нэг болгон дүгнэх тухай заасан ч Төрийн албаны зөвлөлөөс баталсан үр дүнгийн гэрээний үлгэрчилсэн загвар, түүний үнэлгээний аргачлалд нарийвчилсан, үр нөлөө бүхий зохицуулалт болж чадахгүй байна. Байгууллагуудаас АТГ-т ирүүлсэн үр дүнгийн гэрээний үнэлгээ нь 70-99 хувьтай байгаа хэдий ч, мэдээлэл хэдэн иргэн хүссэн, хүсэлтэд хэрхэн хариу өгсөн тухай тоон мэдээлэл байхгүй, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлыг /30 хоногт/ үзүүлэлт болгосон нь үнэлгээний шалгуур үзүүлэлт тодорхой бус, учир дутагдалтай байгааг харуулж байна.

## МЭДЭЭЛЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ӨГӨХ

МИТБМАЭ тухай хуулийн 15 дугаар зүйлд иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргаж, хариугаа авах тухай заасан ч хэрэгжих боломжгүй байна.

Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан [мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмын 4.2](#) дахь хэсэгт “байгууллагын цахим хуудас дахь [мэдээлэл нь албан ёсны байх тул](#) иргэн, хуулийн этгээд нь сургалт, судалгаа, шинжилгээ, мэдээллийн зорилгоор ашиглаж болно” гэж заасан ч мэдээлэл шинэчлэлтийн хурд, агуулгын олон талт, хэрэгцээт байдал хангалтгүй хэвээр байна.

2011 оны 12 сарын 15-ны өдөр Цахим гарын үсгийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолыг УИХ-аас баталж хүчин төгөлдөр мөрдөж буй хэдий ч, цахим баримт бичиг үйлдэн, тоон гарын үсэг зурах боломж бүрдээгүй, түлхүүр кодтой болох үйл явц удаашралтай байна.

Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор баталсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн гуравдугаар зорилт нь “Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох” байгаа юм. Тус хөтөлбөрийн 5.3.5 дахь хэсэгт “төрийн үйл ажиллагааны талаар иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэдийн оролцоог хангах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх, хариу өгөх цахим үйлчилгээг бий болгох” –оор заасан нь мөн л мэдээлэл хүссэн хүсэлтийн хүлээн авах, түүнд хариу өгөх тухай зохицуулалтыг орхигдуулсан.

“Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” нь байгууллага ил тод байх мэдээллээ цахим хуудсанд оруулж, түгээх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулсан ба байгууллага нь хууль, уг журамд нийцүүлэн өөрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангахаар дотоод журам боловсруулан мөрдөж болохоор заасан.

Төрийн байгууллагуудын мэдээллийг цахимжуулах, нэгтгэх, түүнийг ашиглах талаар Засгийн газрын хэд хэдэн журам батлагдаж, мөрдөгдөж байна. Үүнд:

- ▶ Төрийн байгууллагын цахим мэдээллийн санг “Үндэсний дата төв” УТУГ-т шилжүүлэн байршуулах тухай, 2012-12-1, №146
- ▶ Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан ашиглах журам, 2013-6-15, №212
- ▶ Мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай, 2013-6-15, №214
- ▶ Байгууллага нь цахим хуудасны агуулга, бүтэц, хөгжүүлэлтэд тавигдах шаардлага MNS 6285:2011 Монгол Улсын стандарт
- ▶ Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг бүрдүүлэх MNS ISO 17799:2007, MNS ISO/IEC 27001:2009; MNS ISO/IEC 13335-1:2009 стандартууд

Мөн Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр МИТБМАЭ-ийн тухай хуулийн 9, 10 дугаар зүйл хүчингүй болох тул дээрх заалтуудтай холбоотой мэдээлэл хүсэх, хариу авах асуудал эргэлзээтэй байдалд үүсч болзошгүй тул нарийвчлан судлах, нэгдсэн ойлголттой болох шаардлагатай юм. Тухайлбал, Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх”-ээр тогтоож, бүхэлдээ цахимаар мэдээллийг ил тод болгохтой холбоотой харилцааг зохицуулсан.

## ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ЭРЭМБЭ БА ПРАКТИК

Судалгааны явцад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийг мэдэхээс илүүтэй “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг батлах тухай Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол, Иргэнээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад өмнө дурьдсан хэм хэмжээний актуудыг удирдлага болгож байна.

Засгийн газрын газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана”, 7 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж нь тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно”, 8 дахь хэсэгт “Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж заасан.

Гэвч УИХ, ЗГ-аас МИТБМАЭ-ийн тухай хууль батлагдан гарч, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай ямар нэг шийдвэр гаргаагүй тул хүчин төгөлдөр хэвээр үйлчилж, [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудсанд идэвхтэй хэвээр байгаа юм.

Эрх зүйн хэм хэмжээний актууд хоорондоо зөрчилдөх тохиолдолд түүнийг эрэмбэлэх аргаар шийдвэрлэдэг дэлхий нийтийн практик байдаг. Эрх зүйн хэм хэмжээний актыг эрэмбэлэх нь онолын хувьд:

- ▶ Нарийвчилсан зохицуулалттай хэм хэмжээ нь ерөнхий зохицуулалтаас илүү хүчинтэй
- ▶ Шинээр батлагдсан хэм хэмжээ нь хуучин хэм хэмжээнээс давуу хүчинтэй
- ▶ Дээд хэм хэмжээ нь доод хэм хэмжээнээс илүү хүчинтэй. /Үндсэн нөхцөл нь нэмэлт нөхцөлөөсөө давуу хүчинтэй/

Монгол улсын иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ”, 3.6 дахь хэсэгт “Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг зөвхөн хуулийн хэм хэмжээг нөхөн зохицуулсан тохиолдолд хэрэглэнэ” гэж заасан нь тус хуулийг албан ёсоор дагаж мөрдөх үүргийг хүлээлгэж байна.

Дээрх Засгийн газрын тогтоолын агуулга, зохицуулалт нь МИТБМАЭ-ийн тухай хуулийн заалтуудтай давхардсан ч, хүсэлт хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх, хариу өгөх хугацаа зэрэг нь ялгаатай, энэ хууль болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх хуулийн дагуу шийдвэрлэхээр өөр өөрөөр зохицуулснаас болж, хууль хэрэгжихгүй, хоёрдмол утгатай болжээ. Төрийн байгууллагын албан хаагчид хуулийн хэрэглээний ойлголт жигд биш, нэгэнт Засгийн газрын тогтоолыг хүчингүй болгох тухай шийдвэр гараагүй тул тус тогтоолоо баримталсан хэвээр байгааг дараах жишээнүүдээс харж болно.

#### Жишээ нь:

Төв аймгийн ИТХ-ын цахим хуудсанд энэхүү Засгийн газрын тогтоолыг 2014 оны 12 сарын 17-ны өдөр [www.tov.khural.mn](http://www.tov.khural.mn) хуудасны шинэ мэдээ хэсэгт шинээр байршуулсан.



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/52

Ховд

Журам батлах тухай

"Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газарт "Хайрцгаар санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

Ховд аймгийн засаг дарга 2014 оны 04 сарын 23-ны өдрийн тушаалдаа Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг үндэслэл болгосон байна.

Түүнчлэн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан нууцын хуулиуд, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлтийг оруулаагүйгээс мэдээлэл авах хүсэлтийг хангахгүй байх боломжууд байсаар байна. Тухайлбал, "Глоб Интернэшнл төв" ТББ-ын Улс төрийн намуудын мөрий хөтөлбөрийг авах хүсэлтэд УДШ-ээс Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн заалтыг үндэслэн мэдээлэл өгөхөөс татгалзсан.

Иймд хууль хэрэглээний ойлголт өгөх сургалт хийх, нөгөө талаар өөр хоорондоо зөрчилдөөнтэй олон хууль, тогтоол шийдвэрүүдийг нарийвчлан судалж, зарим хэсгийг хүчингүй болгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хууль нэг мөр ойлгогдож, хэрэглэгддэг практикийг тогтоох ажиллагаа тулгамдсан асуудал болж буйг судалгааны энэ хэсэг нотолж байна.

## МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ


### Хуулийн талаарх ерөнхий ойлголт

МИТБМАЭ-ийн тухай хуулийн талаар удирдах албан тушаалтнууд нь гүйцэтгэх албан тушаалтнуудаас илүү мэдэж байна. Харин хуулиас илүү Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг иш үндэс болгон ярих мөн 4 төрлийн мэдээллийг цахим хуудас, самбарт байршуулж, ил тод болгох ёстой гэсэн ойлголттой байна.

2013 онд Глоб Интернэшнл Төв ТББ-аас “Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, Монголд ил тод шударга байдлыг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд 8 аймгийн 20 сумдын нийт иргэдийг төлөөлүүлж, 1948 түүвэрт үндэслэн Суурь судалгааны тайлан бэлтгэсэн.

Тус судалгаагаар, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг хэр сайн мэдэж байна вэ? Нийт судалгаанд оролцогчдын 9 хувь нь энэ хуулийн талаар Маш сайн, сайн гэж хариулсан бол хариулаагүй иргэдийг нэг талаасаа мэдэхгүй гэж ойлгож болох юм. (Зураг.)

*Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэр сайн мэдэх вэ?*



Аймаг тус бүрээр 1-5 оноогоор үнэлэхэд Баян-Өлгий аймаг хамгийн сайн (3 оноо), Өвөрхангай аймаг хамгийн муу (3.6 оноо) мэдэж байна. Нийт үзүүлэлтээс харахад 3,1 оноотой байгаа ба хуулийн мэдлэгийн тархалж жигд байна. Үндсэндээ мэдээлэл авах эрхтэй гэдгээ мэддэг, мэдээлэл авах эрхийн тухай хуулиа сайн мэддэг иргэд нийт судалгаанд оролцогч иргэдийн 3,7-4,7 хувийг эзэлж байгаа юм.

Иргэдийн хувьд төрийн байгууллага нээлттэй ил тод, хурдан шуурхай ажиллах ёстой гэсэн ерөнхий ойлголттой. Ялангуяа төрийн байгууллагаас хуулиар заасан 4 төрлийн мэдээллийг авах гэхээсээ илүү төрийн үйлчилгээ авахтай холбоотой мэдээлэл авсан байна. Мэдээлэл цуглуулах явцад төрийн байгууллагаас мэдээлэл авсан иргэд нь ихэвчлэн тохиолдлын шинжтэй байсан бол цөөн тооны ТББ, Хуулийн этгээдийн тухайд МИТБМАЭ-ийн тухай хуулийг иш, үндэс болгосон байв

Суурь судалгааны тайлан, 2013 он, Глоб Интернэшнл төв ТББ

Мэдээлэл дээд зэргээр нээлттэй байх, хязгаарлалт нь нарийвчилсан байх, хязгаарлалтын үндэслэлээ тодорхой нотолж чаддаг байхыг албан тушаалтнаас шаардах чадварыг иргэдэд бий болгох нь чухал. Иргэн нь мэдээлэл хүсэх идэвхтэй хандлагатай болсноор хууль бодит утгаараа хэрэгжинэ. Мэдлэг мэдээлэлтэй иргэд хяналтаа сайн тавьж, төр засгийн үйл ажиллагаа, нийтийн хөрөнгийн захиран зарцуулалт, шударга ёсыг сахиулахад хувьд нэмрээ оруулах боломжтой болно.

Энэхүү судалгааны зорилго нь мэдээллийн самбар, цахим хуудсаар мэдээллээ ил тод болгож буй практик, мэдээллийг тогтмол шинэчлэх, тухай бүр шинэчлэх асуудал, агуулгын тал, зөрчил дутагдалтай талыг судлахад чиглээгүй тул хуулийн хэрэгжилтийн ерөнхий дүр зураг, чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ, сайн туршлагыг илүү харсаныг дурдах нь зүйтэй.

## МЭДЭЭЛЛИЙН САМБАР

Судалгаанд хамрагдсан байгууллагууд Ил тод, нээлттэй байдлын самбартай. Энэ нь хуульд заасан 4 төрлийн мэдээлэл болох хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үйл ажиллагааны ил тод байдал, мэдээ мэдээлэл, өргөдөл, гомдол гэсэн хэсгүүдээс гол төлөв бүрдсэн. Тус хэсгүүдэд мэдээлэл ямар нэг байдлаар байршсан. Мөн үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг самбарт байршуулах, тараах жижиг хуудас хэвлэх зэрэг давуу талууд ажиглагдсан.

Үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл, зарчим, тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх хуулийг ишлэл болгох зэргээр мэдээллийн самбарын хувьд стандарт жишиг бий болсон байна.

Төв аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын өрөөний үүдэнд ажлын байрны зорилго, үйлчилгээ үзүүлэх чиглэл, иргэд хүлээн авах цагийн хуваарь зэргийг байршуулсан нь давуу талтай байсан.

Төрийн байгууллагууд электрон самбар, урсдаг гэрлэн самбар, цахим машинууд бий болсон дэвшилттэй зүйл зүйл байв. Судалгааны үед зарим байгууллагын электрон дэлгэц, цахим ТҮЦ машин түр ажиллахгүй байгаа нь ажиглагдсан.

## ЦАХИМ ХУУДАС

Байгууллагууд гол төлөв gov.mn өргөтгөлтэй цахим хуудастай, бүх аймаг, нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын нэгдсэн www.khural.mn цахим хуудсыг Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх төслөөс санаачлан бүтээж, шинэчлэл идэвхтэй хийгдэж байна.

Иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэх чиглэлээр хийгдсэн ажлууд:

- ✓ Угтах ажилтан
- ✓ Үнэлгээний төхөөрөмж
- ✓ Электрон мэдээллийн цахим дэлгэц
- ✓ Дугаарлалтын төхөөрөмж
- ✓ Албан ажлын байранд зайлшгүй мөрдөх санамж
- ✓ Цаг бүртгэлийн систем
- ✓ Аль хорооны иргэн хэнээс үйлчилгээ, мэдээлэл авахыг тодорхой болгосон.

*Баримтжуулалтыг хавсралт №1-ээс үзнэ үү.*

## САНАЛ ХҮСЭЛТИЙН ХАЙРЦАГ, ДЭВТЭР

Сарбүрийн тогтсон өдөр хайрцагийг нээж, танилцуулж, асуудлыг шийдвэрлэхээр хуваарилдаг тогтолцоо бий болсон байна.

Иргэний танхимаар дамжуулан иргэдийн санал, хүсэлт, талархлыг хүлээн авдаг. Мөн энэхүү хүсэлтүүдийг Засаг даргын зөвлөлийн хурлаар долоо хоног бүрийн нэг тогтсон гарагт хэлэлцэх асуудлын эхэнд оруулж хариуцан шийдвэрлэх албан тушаалтанд шилжүүлж, хариуг иргэний танхимаар дамжуулан өгдөг ажээ.

## ХАНДЛАГА

Мэдээлэл өгөх хандлагын хувьд эерэг хандлагатай. Тайлбарлаад очиход Баянзүрх дүүргийн халамж үйлчилгээний хэлтэс, ИТХ, Сонгинохайрхан дүүргийн газрын албанаас бусад байгууллагын удирдлага эерэг хандлагатай, цаг зав гаргаж ярилцах, холбогдох ажилтнуудтай уулзуулах, танилцуулах зэргээр нээлттэй байв.

Баянзүрх дүүргийн Халамж, үйлчилгээний хэлтсийн удирдлагын хувьд мэдээлэл авах зорилго, ажлын үнэмлэх шаардаж, мэдээлэл өгөхөөс болгоомжилж /хардах эрхтэй гэж тайлбарласан/, аль болохоор зайлсхийж байв.

Судалгааны ерөнхий байдлаас ажиглахад, иргэд мэдээлэл авах хүсэлт гаргахаасаа илүү төрийн үйлчилгээний байгууллагад үйлчилгээ авахаар ханддаг бол, нутгийн удирдлагын байгууллага, төрийн захиргааны байгууллагад асуудал шийдвэрлүүлэхээр ханддаг тул тус тусын хуулиар буюу тухайлбал, судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд Нийгмийн халамжийн тухай хууль, Газрын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль зэргийг үндэслэн шийдвэрлэдэг практик тогтсон байна.



### 23 дугаар зүйл. Тэмдэглэл хөтлөх

23.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах боломжийг хангах зорилгоор тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

23.1.1. мэдээлэл авах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг;

23.1.2. мэдээлэл авах хүсэлт хүлээн авсан, хянасан буюу буцаасан, мэдээллийг өгсөн хугацаа;

23.1.3. бусад.

### 14 дүгээр зүйл. Мэдээлэл өгөх

14.10. Хүсэлтийн хариуг өгсөн он, сар, өдөр, хариу бэлтгэсэн албан тушаалтны нэр, мэдээлэл олгосон хэлбэр зэргийг бүртгэлд тэмдэглэн хадгална.

## ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсэгт мэдээлэл хүсэгч нь мэдээлэл авах хэлбэрээ сонгох, шаардлага үндэслэлээ тайлбарлахгүй байх эрхийг баталгаажуулж, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэгт мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр өгөх, мэдээлэлтэй биечлэн танилцаж болохоор хуульчилсан.

### Хүсэлт хүлээн авах суваг:

Төрийн байгууллагын иргэн, хуулийн этгээдээс ирж байгаа хүсэлтийг хүлээн авч буй хэлбэрүүд:

Байгууллага дээрээ	Цахим хуудас	Олон нийтийн сүлжээ	Нэгдсэн мэдээлэл авах суваг
<ul style="list-style-type: none"> <li>• Бичгээр</li> <li>• Амаар/биечлэн</li> <li>• Санал, хүсэлтийн хайрцаг</li> <li>• Иргэдийг хүлээн авах төв</li> <li>• Албаны болон тусгай утас</li> <li>• Нээлттэй хаалганы өдөр зэрэг арга хэмжээний үеэр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Санал, хүсэлт авах хэсэг</li> <li>• Цахим шуудан</li> <li>• Санал, хүсэлт хүлээн авах шууд чатаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Фейс бүүк</li> <li>• Твиттер</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын 11-11 төв</li> <li>• Иргэд хүлээн авах төв</li> <li>• 1200, 1800 тусгай дугаар</li> <li>• www.ub1200.mn</li> <li>• Ухаалаг утас SMART</li> <li>• www.smartcity.mn</li> </ul>

- ▶ Иргэн, хуулийн этгээдээс ирж байгаа өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн,
- ▶ Утсаар ирж байгааг утасны оператор, иргэдэд үйлчлэх төв, иргэний танхимын ажилтан,
- ▶ Цахим хуудас, мэйл хаягаар ирж байгааг мэдээлэл, инженер техникийн ажилтнууд голлон хүлээн авч бүртгэдэг.

Мэдээлэл хүсэгч мэдээлэл авах хүсэлтээ аль ч хэлбэрээр гаргасан тэмдэглэл хөтлөгдөж, 14 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу хариуг мөн бүртгэлд тэмдэглэн хадгалахаар хуульчилсан.

*Энэ хүрээнд мэдээлэл хүсэгч, түүнд хариу өгч буй байдлын зураглал гаргавал:*

Хүсэлт гаргах хэлбэр	Хариу өгөх хэлбэр	Бүртгэлийн тогтолцоо	Хянан шийдвэрлэх хугацаа	Хяналт, үнэлгээ
Амаар	Амаар	Байхгүй	Албан тушаалтны үзэмжээр	Байхгүй
Утсаар	Амаар	Цөөхөн байгууллагад утасны бүртгэл хөтөлдөг.	Албан тушаалтны үзэмжээр, эсвэл 30 хоногт	Байхгүй

Цахимаар /цахим хуудас, олон нийтийн сүлжээ, электрон шуудангаар/	Цахимаар	Тогтсон стандарт байхгүй	Албан тушаалтны үзэмжээр	Байхгүй
Бичгээр	Бичгээр	Өргөдөл гомдлын дэвтэр, эсвэл ирсэн, явсан бичгийн бүртгэлийн дэвтэр, эсвэл дотоод программ	30 хоног өргөдөл гомдлын хуулиар шийддэг.	Мэдээлэл авах хүсэлтийн тоо, чанарын үзүүлэлтийг ялгаж ангилах боломжгүй
Иргэний танхим, 1111 төвүүдэд утсаар, эсвэл биечлэн хандах	-Утсаар хариу өгнө. -Хүсэлт гаргавал бичгийн хуулбар олгох	- Able - Smart зэрэг тусгай програм ашиглан мэдээллээ солилцдог	30 хоног	Өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал гэсэн ангиллаар мэдээлэл бүртгэгддэг тул нарийвчилсан үнэлгээ хийх боломжгүй

Дээрх хүснэгтээс хуулийн 23 дугаар зүйлийн “гол цөм” болсон **“хуулийн хэрэгжилтийг шалгах боломжийг хангах зорилго”**-доо нийцэхүйц тэмдэглэл хөтөлдөг механизм, тэмдэглэл хөтлөх субъект, тэмдэглэлийн нэгдсэн стандарт байхгүй байна.

Нийт судалгаанд хамрагдсан 64 төрийн байгууллагаас 63 (98,4%) буюу Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас бусад нь өргөдөл гомдлын дэвтэрт иргэдээс ирсэн хүсэлтийг, хуулийн этгээдээс ирсэн албан бланктай хүсэлтийг ирсэн бичгийн бүртгэл, явсан бичгийн бүртгэлийн дэвтэрт бүртгэж байна.

Нэг (1,56 %) буюу Баянхонгор аймгийн ИТХ “Мэдээлэл хүсэгчийн бүртгэл” гэсэн дэвтэртэй. 2011 оны сүүлээр энэ дэвтрийг нээсэн. Бичгээр, амаар, утас (70440001)-аар ирсэн бүх хүсэлтийг тус дэвтэрт бүртгэдэг тул асуудал шийдвэрлүүлэхээр ирүүлсэн өргөдөл, хүсэлттэй холилдсон, хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах хууль нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль байна.



Сайн жишээ 1. Баянхонгор аймгийн ИТХ тусгайлан дэвтэр гаргаж тэмдэглэл хөтөлж байна.

*Мэдээлэл хүсэгчийн бүртгэлийн дэвтрийн толгой*


№	Ирсэн хүсэлт				
	Сар өдөр	Дугаар	Хаанаас, хэнээс	Товч утга	Хуудасны тоо
1	2	3	4	5	6
Бүртгэж шилжүүлсэн					
Сар өдөр	Аль хэлтэс, тасгийн хэнд шилжүүлсэн		Хүлээн авсан хүний гарын үсэг	Шийдвэрлэлт /Хэзээ, хэрхэн/	

2011 оноос хойш мэдээлэл хүсэгчийн дэвтэрт бүртгэгдсэн хүсэлтийн тоо

	Нийт	2011 он	2012 он	2013 он	2014-11-24
“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” хэрэгжиж эхэлсэн өдрөөс (2011/06/16) хойш хэдэн хүсэлт танай дээр ирсэн бэ?	626	150	171	170	135
Үүнээс: Хугацаанд нь шийдвэрлэсэн.*	626	150	171	170	135

\*Дээрх дэвтрийг хөтөлдөг хүнээс шийдвэрлэсэн хугацааг лавлахад өргөдөл гомдлын хуулийн дагуу 30 хоногийн дотор шийдсэн гэж хариулсан.

Нийслэлийн төр захиргааны байгууллагууд бүртгэлийн дэвтэрт бүртгэхээс гадна давхар [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) бүртгэж байна.



Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд албан хаагчидтай хийсэн ярилцлагын явцад цаашид цаасан хэлбэрийн бүртгэлээс татгалзаж, цахим хэлбэрт оруулах хүсэл, сонирхол, зорилготой байгаа нь ажиглагдсан. Судалсан байгууллагуудаас Улаанбаатар

хотын захирагчийн албаны харъяа агентлаг Нийслэлийн өмчийн харилцааны газар, Иргэдэд үйлчлэх төв, Тамгын газар зэрэг нь өргөдөл, гомдол, хүсэлт, албан бичгийн бүртгэлийг шууд цахимаар бүртгэж, хянан шийдвэрлэх процедур нь нэлээд цэгцтэй явагддаг ч мэдээлэл хүсэх хүсэлт гэсэн тусгай ангилал байхгүй байна.

Энд мэдээлэл авах хүсэлт үү? Үйлчилгээ авах хүсэлт үү? гэдгийг нарийн зааглахгүй бүртгэснээр МИТБМАЭ-ийн тухай хуулийн хариуг шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр, хугацаа шаардлагатай бол ажлын 7 өдрийн дотор хариу өгөх тухай хуулийн заалт зөрчигдөх байдал нийтлэг ажиглагдсан.

Тодруулбал, МИТБМАЭ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө”, 14.9 дэх хэсэгт “Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 14.8-д заасан хугацааг нэг удаа 7 хоногоор сунгаж болно” гэж заасан.

Харин Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолийн хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийн 1.7 дэх хэсэгт “Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх” гэж заасан нь хоёрдмол байдлыг бий болгож, төрийн албан хаагчид Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн 4 дахин илүү хугацаа буюу 30 хоногийн хугацаанд шийдвэрлэж, чирэгдүүлэх, мэдээллийн үнэ цэнэ алдагдахад хүргэж байна.


Захиргааны байгууллагад асуудлыг шийдвэрлүүлэхээр хандах нь түгээмэл байдаг бол төрийн үйлчилгээний байгууллагаас илүү үйлчилгээ авахаар, өргөдөл, хүсэлт, гомдол гаргах, шаардлагатай тохиолдолд бичиг баримт бүрдүүлэлтийн талаар ханддаг тулбичиг баримтын бүрдүүлбэл, үйлчилгээний маягт, загваруудыг мэдээллийн самбар, цахим хуудас, мэдээлэл бүхий тасалбар, эсвэл угтах үйлчилгээний ажилтан зөвлөгөө өгөх, амаар болон утсаар асуултад хариулах хэлбэрээр шийдэж байна.

Дээрх байдлаас үзэхэд, төрийн албан хаагчид Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолыг барьж ажилласан, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн мэдлэг хангалтгүй байгаа нь давхар нотлогдож байна. Нөгөө талаас, хууль хэрэглээний эрэмбэллийг мэдэхгүй байна.

Бүх шатны төрийн байгууллагууд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЗГХЭГ-т улирал, хагас, бүтэн жилээр хүргүүлдэг ч энэ дотор мэдээлэл хүссэн хүсэлт, түүний шийдвэрлэлтийн талаар тоон мэдээлэл байхгүй.

Аймгуудын цахим хуудсанд хийсэн ажиглалтаар Увс аймгийн Цахим өргөдөл


гомдлын систем бусдаас давуу талтай байсан.



Сайн жишээ 2. Увс аймгийн Цахим өргөдөл гомдлын систем

Энэ систем нь утас, биечлэн, цахим хуудас, facebook, twitter, e-mail гэсэн зургаан сувгаар өргөдөл, гомдол, санал хүсэлт авна. Хүсэлтийг шийдсэн, шийдээгүй, аль сувгаар ирүүлсэн болохыг шүүж харах боломжтой зохиогдсон байна. Гэхдээ энд мөн л мэдээлэл авах хүсэлт, асуудал шийдвэрлүүлэх, асуулт холилдож бүртгэгдсэн тул тоон мэдээлэл гаргах боломжгүй байна.

### Кейс 1. Дасаг даргын мөрийн хөтөлбөр хүссэн



## Кейс 2. Цахилгааны үнэ тодруулсан.

The screenshot shows the Able system interface. At the top, there is a header with the company name "Цэвэр иргэдэд гомдлын систем 70452222 ТББ" and navigation options like "Саналууд", "Газрын зураг", and "Хэлэлцүүлэг". A search bar contains "Саналын №" and a "Санал оруулах" button. On the left, a sidebar lists navigation options: "Бүх суваг", "Утсвэр", "Бивчлэн", "Цахим хуудас", "Файсбүүк", "Твиттер", and "Имэйл". The main content area displays a call log entry for "№ 1410160009" with a status of "Мэдээлэл авахыг хүссэн". The text of the call states: "Цахилгааны үнэ нэмээдээд байна. 1 Квт нь 60 төгрөг байсан, 70, 80 төгрөг болсон одоо 86 төгрөг болсон байна. Өнөөдөр мөрдөж байгаа цахилгааны үнийн талаар мэдээлэл өгнө уу." Below the text are three response cards from "Д.Оюу, С.Ц. Албан тушаал" (D. Oyuu, S. T. Position). The first card says "Бүртгэсэн". The second card, titled "Шигээүүлсэн", provides information about the "Удирдлагын заалт" (Management Regulation) and the "Хан рүү" (To the office) address. The third card provides the "Хэрж" (Cost) of the service, stating it is 78.000 Mongolian Tugrik per kWh.

Дундговь, Төв аймаг болон бусад 10-аад аймагт нэвтрүүлээд буй Able систем нь мөн мэдээллийг олон сувгаар хүлээн авч, бусад холбогдох байгууллагуудтай шилэн кабелиар холбогдсон тул шууд албан тушаалтанд очиж, шийдвэрлэгдэж, эргэж Иргэний танхимаараа дамжин хариу иргэндээ очдог. Техникийн шийдэл, програмчлал, цаас хэрэглээгүй, шат дамжлага цөөн, асуудал хаана явааг хянах боломжтойгоороо давуу талтай хэдий ч, хуулийн 23 дугаар зүйлийн зорилтыг хангахуйц мэдээллийн тэмдэглэл болж чадахгүй байна.

Иймд мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, хянан шийдвэрлэх хугацаа, мэдээлэл өгөх эзэн нь тодорхой бус, байгууллага, албан тушаалтны үзэмж, хандлагаар шийдвэрлэгдэж байгаа учир бүхэлд нь энэ зүйлийн хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэв.

### МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН АЖИЛТАНТАЙ БАЙХ

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь хэсэгт “үйлчилгээ, захидал харилцааны асуудал эрхэлсэн албан хаагчийн тухай, 11 дүгээр зүйлийн 11.2



дахь хэсэгт мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа холбогдох албан тушаалтан, 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсэгт хүсэлтийн хариуг бэлтгэсэн албан тушаалтны нэр, мэдээлэл олгосон хэлбэр зэргийг бүртгэлд тэмдэглэн хадгалах тухай, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмын 3.3. байгууллагын удирдлага нь ... цахим хуудсанд хуульд заасан мэдээллийг оруулах, өөрчлөх, устгах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах асуудлыг хариуцсан ажилтныг томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавина зэргээр мэдээлэл өгөх, ил тод байдлыг хангах үүрэг хүлээх ажилтан байх тухай ерөнхий агуулга харагдаж байна.

Харин тухайн албан хаагч нь чухал ямар эрх зүйн байдалтай этгээд байх, түүний орон тоо, төсвийн асуудлыг тухайлан шийдвэрлээгүй тул хуулийн хэрэгжилтийг гардан хариуцах эзэнгүй болсон байна.


Нийт судалгаанд хамрагдсан 64 байгууллагад Мэдээллийн ажилтан гэсэн нэр томъёогоор нэрлэгдсэн албан хаагч байгаагүй. Харин иргэд, хуулийн этгээдээс ирсэн хүсэлтийг хүлээн авч, ямар нэгэн байдлаар тэмдэглэл хөтөлдөг албан хаагч байсан. Үүнийг багцлан авч үзвэл дараах таван бүлэг харьяалагдаж байна. Үүнд:

- Угтах болон иргэдийг хүлээн авах төвийн ажилтан, утасны оператор
- Мэдээ мэдээлэл олон нийттэй харилцах, өргөдөл санал гомдол, эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтэн
- Даргын туслах, архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан
- Хүний нөөц, хуулийн хэлтсийн ажилтан
- Мэдээлэл технологийн ажилтан

Дээрх олон төрлийн ажил үүргийн хуваарь бүхий ажилтнууд тухайн асуудлаасаа хамааран иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авах ажлыг хавсарган гүйцэтгэж байгаа, “бичиг дамжуулагчийн” эрх хэмжээтэй ажиллаж, ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн бичиг бүрийг даргад танилцуулан, цохолт хийлгэх, хариуцсан ажилтанд хуваарилуулах, мэдээллийн эмх замбараагүй дүр зураг харагдаж байгаа юм.



Сайн жишээ 3. Төв аймаг. Ажилтан бүрийн ажил үүрэг, холбогдох мэдээллийг танилцуулсан.



ИРГЭН – Угтах үйлчилгээний ажилтан - Иргэдийн эрэлт хүсэлт хариуцсан мэргэжилтэн – Хэлтсийн дарга / Засаг дарга – Хэлтсийн дарга – Мэргэжилтэн – Иргэн/ Иргэдийн эрэлт хүсэлт хариуцсан мэргэжилтэн – ИРГЭН

Иргэдийн эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтэн нь ирсэн хүсэлтүүдийг өргөдөл, гомдлын дэвтэрт, [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) системд бүртгэж авдаг. Үүний дараа тухайн хүсэлт хэнд хандсанаас шалтгаалан холбогдох мэргэжилтэн, эсвэл шийдвэрлэх удирдлагад шилжүүлнэ. Хүсэлтийн хариуг мэргэжилтэн шийдвэрлээд, иргэнд хариуг нь өгч, [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) шийдвэрлэлтийг тэмдэглэдэг. Эсвэл мэргэжилтэн хариуг өөрөө иргэнд шууд өгөлгүй Иргэдийн эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтэнд шилжүүлдэг байна.

Иргэдийн эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтэн болон хүсэлтийг шийдвэрлэх бусад мэргэжилтэн аль аль нь шийдвэрлэлтийн хариуг [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) тэмдэглэдэг гэж байгаа боловч дэвтрийн бүртгэл цаг тухай бүртээ зөв, бүрэн бүртгэгдэхгүй байх эрсдэлтэй.

Тухайн байгууллагад бичгээр, амаар, цахимаар, утсаар ирж байгаа бүгдийг нэг хүн бүртгэх нь эмх цэгцтэй ч олон хүн амтай төв суурин газар ажлыг дангаар гүйцэтгэж боломжгүй байж болох тул байгууллагын ачааллаас хамааран дотоод зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолтод гүйцэтгэх үүргүүдийг нарийвчлан тодорхойлж өгөх шаардлагатай. Ялангуяа, мэдээллийн ажилтанг мэдээллээр хангах, өөрсдийн хариуцсан ажил үүргийн хуваарьт хамаарах мэдээллийг хуулийн хугацаандаа тухай бүр хүлээлгэн өгч, тухайн байгууллагын мэдээлэл нэг цэгт

төвлөрөн системчлэгдсэнээр шуурхай, хүртээмжтэй, нээлттэй байх зарчмууд хэрэгжих боломжтой болно.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын энэ зүйлийг хэрэгжүүлэхийг оролдож буй сайн жишээ, санаачлагууд байгааг тэмдэглэх нь зүйтэй хэдий ч, дээрх зорилгод бүрэн нийцсэн, мэдээлэл хүсэх хүсэлт бүрийг хэлбэрээс үл хамааран бүртгэх тэмдэглэх бүртгэлийн тогтолцоо байхгүй байна.

Завхан аймгийн Засаг даргын Тамгын Газарт Хүсэлт Гаргах Тамга

23. ОНН - СЭЖМН - ӨДӨР Улаанбаатар

Мэдээлэл авах тухай

**A. Хүсэлт гаргах шалтгаан, үндэслэл**

**B. Хүйс, гэрээ, гэрээний нөхцөл**

1. Эрхтэй өвөр: ..... 2. Өгчтэй нэр: ..... 3. Нэр: .....

4. Төрсөн өнөө: ..... 5. Иргэний дугаар: .....

7. Хүйс, гэрээний нөхцөл: ..... 8. Ажлын газар, албан тушаал: .....

9. Оршин суух ажил: .....

12. Гэрээний үндэс: ..... 13. Гэрээний үндэс: .....

17. Ажлын үндэс: ..... 18. И-Мэйл: .....

**C. Мэдээллийн төсөл**

- үйл ажиллагааны ил тод байдал
- мэдээллийн ил тод байдал
- төлөв, санхүүгийн ил тод байдал
- төрийн болон эрх зүйн ажиллагааны үнэмлэхүй үндэслэл авах ажиллагааны ил тод байдал

Гэрээг төвийг! /Мэдээллийн агуулга болно!

Хүсэлт гаргах өгчийн нэвчилсэн үйл: ..... Өндөр: ..... / .....

**Завхан эрх зүйн ажлын төлөө.**

Адрес: мэдээлэл, гэрээ, дугаар: .....

Байгууллагын нэр: .....

Мэдээллийн өгчийн нэр: .....

Төрийн нэр: .....

#### Сайн жишээ 4. Завхан аймгийн ЗДТГ Мэдээлэл авах тухай маягттай.

2014 онд ганцхан иргэн төсөвтэй холбоотой мэдээлэл авахаар хүсэлт гаргасан үүнээс үүдэн доорх маягтыг боловсруулан гаргасан байна.

Дээрх маягтыг боловсруулж буй санаачлага нь сайн. Гэвч хуулийн 11 дүгээр зүйлтийн 11.3 дахь хэсэгт заагаагүй төрсөн огноо, хүйс, ажлын газар, албан тушаалыг тусгаж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дэх хэсэг заасан “мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх эрх”-ийг зөрчиж “хүсэлт гаргах шалтгаан, үндэслэл”-ийг шаардсан зөрчлүүдийг өөрчлөх хэрэгтэй байна.

Сайн жишээ 5. Дорноговь аймгийн 70520003 утсанд ирсэн мэдээллийг маягт дээр бичиж авдаг.

Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын хавсралт

Өргөдөл, гомдол хүлээн авах маягтын үлгэрчилсэн загвар

№ \_\_\_\_\_  
**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАХ МАЯГТ**

Иргэний овог, нэр: \_\_\_\_\_

Иргэний регистрийн дугаар: \_\_\_\_\_

Иргэний оршин суугаа хаяг: \_\_\_\_\_

Холбоо барих утасны дугаар: \_\_\_\_\_

Өргөдлийн төрөл: (Дараах ангилалаас сонгоно уу?)

Талархал  Санал  Хүсэлт  Гомдол  Мэдэгдэл

Тухайн асуудлаар өмнө нь аймгийн нутгийн захиргааны байгууллагад хандаж байсан эсэх:

Тийм  Үгүй

Өргөдлийн төрөл хэлбэр:

Амаар бичлэн,  Тусгай дугаарын утсаар,  Бичгээр,  E-mail хаяг,

(Хэнд, хаани хандаж байгаа тухай мэдүүлэл)

Агуулга: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Өргөдөл гаргасан: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_  
(Гарын үсэг)

Хүлээн авсан: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_  
(Гарын үсэг)

Удирдлагын заалт

\_\_\_\_\_

Шийдвэрлэсэн байдал:

\_\_\_\_\_

Сайн жишээ 6. Өмнөговь аймгийн ЗДТГ Санал хүсэлт шийдвэрлэх хуудастай.

**БАТДАВ**  
ОЛОН НӨНДӨР ХАРИЛЦАХ АЛБАНЫ  
ДАРГА Р.ОЮУНСҮРЭН

**"ИРТЭЭЭЭ СОНГОХ - 785000" УТАСНЫ  
САНАЛ ХҮСЭЛТ ШИЙДВЭР, ӨЛТИЙН ХҮУДАС**

2014 оны 09 сар 01 өдөр № 0000126 Давуулагч

1. Иргэний санал хүсэлт:

Мандаг сумын 12 айлын орон сууцны төлөвтөлбөр өрж байна. Мандаг сумд нь 2013 онд өдөр тутамд орон сууцны төлөвтөлбөр өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна.

2. Уг асуудлаар хялбардох байгууллагаас хариу өгсөөр байсан:

Эгээр дараах дараах өмнөговь аймгийн дарга гэрээгээр хариу өгсөөр байсан.

АИТДүрвэл Төрмөнхүүгийн 2014 оны 09 сар 01 өдөр хариу өгсөөр байсан. Мандаг сумын 12 айлын орон сууцны төлөвтөлбөр өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна. Энэ төлөвтөлбөр өрж төрийн алба хэргийг зохиоход саян тэрэг тийш өрж байна.

3. Хариу өгсөн байгууллагын  
Албан тушаалтан: Дорно Монгол улс

4. Хариу өгсөн өмнөговь аймгийн ЗДТГ-ны дарга: М.Дүрвэл

2014 оны 09 сар 01 өдөр

Сайн жишээ 7. Дорноговь аймгийн ИТХ Санал хүсэлт шийдвэрлэх хуудастай.

**САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭХ ХУУДАС**

---

Албан тушаал \_\_\_\_\_

---

Бүртгэсэн		Хаанаас ирүүлсэн	Ирсэн бичгийн		
Карт №	Он сар өдөр		Дугаар	Сар өдөр	Хуудасны тоо
Товч утга					

Сар өдөр	Удирдлагын заалт	Шийдэх хугацаа	Хугацаа сунгасан тухай тэмдэглэл

Судалж шалгасан болон арга хэмжээний тухай дүгнэлт гаргасан шийдвэр, өгсөн хариуны тухай тэмдэглэл, хариуцаж шийдвэрлэсэн хүний албан тушаал, гарын үсэг, нэр

.....

.....

.....

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

### **24 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт**

24.1.Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

24.2.Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуурын нэг болгон дүгнэнэ.

МИТБМАЭ-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хуулийн үйлчлэлд хамаарах байгууллага, түүний албан тушаалтнууд дараах байдлаар хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж ажиллах боломжтой.

Хуулийн энэ заалтыг хэрэгжилтийг хангах гол мэдээлэл нь 23 дугаар зүйлд заасан тэмдэглэл болох учиртай ч, энэхүү тэмдэглэгээ хөтлөлт хангалтгүй байгаагаас хэрэгжилтэд бодитой хяналт тавих боломж хязгаарлагдаж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад засгийн газрын тогтоол шийдвэрийг үндэслэн АТГ, ЗГХЭГ, ИТХ болон бусад холбогдох байгууллагад тайлан хүргүүлэх, зориулан мэдээлэл судалгаа гаргах зэргээр хяналт мониторинг хийгдэж байгаа ч бидний судалж буй 23, 24 дүгээр зүйлд хамаарах тоон мэдээлэл дурдагдаагүй, өргөдөл, гомдол гэдэг нэр томъёонд “мэдээлэл хүссэн хүсэлт”-ийг хамруулан ойлгож, ялгааг гаргахгүй байгаа учир энэ тоонд иргэдийн мэдээлэл хүссэн хүсэлт багтаж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар нэгтгэн, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг байна.

Тус тайлан гаргахдаа Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Иргэдээс нутгийн захиргааны байгууллагад гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай журам, Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг үндэслэн ажилладаг байна.

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмыг захиргааны байгууллагын үйл ажиллагаа, Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлыг зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр, бодлогын баримт бичгээр Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн заалт, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах болон тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэхэд мөрдөж байна.

Энэхүү журмын хавсралтын 22 зүйлд Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн нэг хавсралт нь “байгуулсан гэрээний үүргийн биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан” байхаар тогтоосны дагуу ил тод байдлын мэдээллийг гаргадаг ч, бидний судалж буй хууль, тэр дундаа 23, 24 дүгээр зүйлийг орхигдуулж, байгууллагууд цахим хуудас, самбар, хэвлэл мэдээллээр мэдээлэл хэрхэн түгээсэн тухай дурьдсан байгаа нь хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд хангалтгүй юм.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 68 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Яамдын засаглалтын үзүүлэлт”-ийг баталсан. Тус үзүүлэлтийн хэрэгжилтийг хангаж, жил бүрийн эцэст тооцон тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосон. Яамдын засаглалтын үзүүлэлтийн 2 дахь үзүүлэлт нь Төсвийн ил тод байдал (Төсвийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох зүйл заалт) гэж орсон. Энэ нь мөн л хуулийн 9 дүгээр зүйл, түүний хэрэгжилтийг харуулдаг.

Төрийн байгууллагуудын хэмжээнд шударга ёс, ил тод байдлыг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг дүгнэдэг, АТГ-д тайлан хүргүүлдэг практик тогтсон байна.

Тухайлбал, Төв аймгийн 2012-2013 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланд, 2012 оныг Мэдээллийн тод байдлыг сайжруулах жил” болгоны хүрээнд Хяналт, шинжилгээ, үнэлгээний тасгаас МИТБМАЭ-ийн тухай хууль болон Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн газрын 143 дугаар тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ дүгнэл өгөв. Төлөвлөгөө 86,58 хувьтай хэрэгжсэн тухай дурьджээ

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНД ТУСГАЖ, ҮНЭЛГЭЭНИЙ ГОЛ ШАЛГУУР  
БОЛГОЖ БУЙ БАЙДАЛ



МИТБМАЭ-ийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуурын нэг болгон дүгнэхээр заасан.


2009 оны 143 дугаар тогтоолын 2 дугаар заалтад “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгож, 3 дугаар зүйлд Засгийн газрын агентлагийн дарга болон Засаг дарга нартай байгуулах үйл ажиллагааны үр дүнгийн гэрээнд ил тод байдлыг илтгэх үзүүлэлтийг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуур болгон дүгнэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгаж ажиллаж байсан.

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, төрийн жинхэнэ албан хаагч-Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ байгуулах үлгэрчилсэн загварыг баталсан. Тус журмын зорилт нь төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай гэрээ байгуулж, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхэд нэгдсэн стандарт тогтоон мөрдүүлэх, гэрээнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээг хуваарилагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг хангахад чиглүүлэн, төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэхэд оршино.

Үр дүнгийн гэрээг төсвийн жил эхлэхээс өмнө байгуулж, тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг дүгнэж өгсөн үнэлгээ нь Төрийн албаны тухай хууль 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ болно. Тухайн шатны Засаг дарга нь орон нутгийн босоо удирдлагатай төрийн байгууллагын төсвийн шууд захирагчийн гэрээний биелэлтийг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор дээд шатны байгууллагад нь хүргүүлдэг, Дээд шатны байгууллагын төсвийн шууд захирагч нь өөртэй нь болон тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг нэгтгэн дүгнэдэг тул судалгааны хугацаанд 2014 оны гэрээний үнэлгээ гарах хуулийн хугацаа болоогүй байсан.

Судалгааны хүрээнд судалгааны багийн гишүүд АТГ-аар дамжуулан 19 аймгаас төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежер, мэргэжилтэнтэй хийсэн үр дүнгийн гэрээний хуулбарыг авах хүсэлт явуулж, хоёр аймаг, хоёр дүүрэгт биечлэн очиж ажиллаад нийт 47 үр дүнгийн гэрээн дээр ажилласан. (Зураг 1.)

Зураг 1. Үр дүнгийн гэрээнд тусгагдсан байдал



Үр дүнгийн гэрээний заалтууд нь байгууллагын зорилт бүрийн хүрээнд ил тод байдлыг хангах тухай ерөнхий агуулгаар орж, үнэлж байгаа практик нь байгууллагын зүгээс цахим хуудас, мэдээллийн самбар, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тоон үзүүлэлтээр хэмжигдэж байгаа ч, үнэлгээний гол үзүүлэлт болгох, иргэдэд мэдээлэл авах эрхийг таниулах сурталчлах, төлөвлөгөө, заавар, удирдамж баталж, түүний мөрөөр иргэдийн идэвхтэй оролцоог хангах ажил орхигдсон байна.

Гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг тусгаж гол шалгуур үзүүлэлт болгон дүгнэнэ гэсэн заалт нь мэдээллийн ил тод байдлыг хангах гэсэн ерөнхий зорилттой байгаа хэдий ч үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн тайлангаас харахад хүний нөөц, санхүүгийн тайлан, үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн худалдан авах зэрэг мэдээллээ цахим хуудсанд байршуулах, орон нутгийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан байдал зэргээр дүгнэдэг ерөнхий дүр зураг харагдаж байна.

Тухайлбал, Төв аймгийн халамж, үйлчилгээний хэлтсийн хувьд хуулийн хэрэгжилтийн талаар сайн ойлголттой, дотоод удирдлагын систем ашиглан мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ажил хэргийн төлөвлөлт, захидал харилцаа, албан бичиг, зар мэдээ байршуулах зэргээр үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангахад ашиглаж байна. Үр дүнгийн гэрээндээ “байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байлгахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар болон үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг ... олон нийтэд сурталчлан нэвтрүүлэх”, Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд “Хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт шинээр орсон өөрчлөлтүүдийн

талаар мэдлэг, мэдээллийг тогтмол авч байхаар тусгасан байна.

Түүнчлэн, ил тод байдлыг хангаж ажилласан үнэлгээгээ иргэдээс ирсэн гомдол, санал хүсэлт гэсэн ойлголтоор тайландаа дурдсан байх ба иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл хүргэсэн статистик тоон үзүүлэлтээр баримтжуулж дүгнэж байгаа нь энэхүү хуулийн хэрэгжилтийг хянахад төдийлөн анхаарсан зүйл байхгүй байна.

Судалсан байгууллагуудаас, Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгууллалтын газрын даргын 2010 оны 05 сарын 21 өдрийн 18 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-тай танилцсан. Энэхүү журмын 2.3 дахь хэсэгт газрын албан хаагч нар жилийн төлөвлөгөөтэй, улирал бүр бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээтэй ажиллана. Тэдний үйл ажиллагааны үр дүнг улирал, жилээр дүгнэж байна. Энэхүү дотоод журмын 8.9 дэх хэсэгт “Байгууллагын нууц, түүнийг хадгалах хамгаалах” заалтууд байна. Энд “байгууллагын хаагч, ажиллагсдын хууль бус үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагчийн нэр, хаяг” байгууллагын нууцад хамаарахаас заасан нь **мэдээлэгчийг хамгаалах эерэг зохицуулалт гэж ойлгогдож байна**. Газрын харилцааны чиглэлээр иргэдэд үзүүлэх үйлчилгээний хуваарьт орсоноос үзэхэд иргэдэд үзүүлэх үйлчилгээнээс гадна, газрын төлбөр, татварын талаарх мэдээлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын холбогдолтой хууль, өмчлөх газрын талаарх мэдээлэл зэргийг өгөхөөр тусгасан байна. Мөн байгууллагын нууцад хамаарах мэдээллийн хүрээг нарийвчлан байгууллагын дотоод журмаараа тогтоож, энэ журам нь ил тод болгосон нь мөн сайн жишиг байна гэж үзэв.

### СУРГАЛТ

Мэдээллийн ажилтантай, түүнийгээ сургадаг эсэхийг тодруулах зорилгоор судалгаанд сургалт байдаг эсэхийг асуухаар төлөвлөсөн ч, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад мэдээллийн ажилтаныг тусгайлан, эсвэл хавсран ажиллуулаагүй тул түүнд зориулсан сургалт хийгдэггүй байна.

Ерөнхий байдлаар авч үзвэл, судалгаанд оролцсон байгууллагаас 47 нь 2014 онд дотооддоо ажилтнуудаа чадавхижуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллан, ажилтнуудын харьцааны соёл, төрийн албан хаагчийн ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг чиглэлээр сургалтуудыг гол төлөв хийжээ. 2014 онд Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 15 аймгийн бүх сумдад ажиллах явцдаа Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар тус тусад нь сургалтуудыг хийсэн.

Мөн “Глоб Интернэшнл төв” ТББ-аас “Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, Монголд ил тод байдал, шударга ёсыг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд Баян-Өлгий, Увс, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Булган, Сүхбаатар, Архангай аймгийн зөвхөн 20 сумын түвшинд иргэд, албан тушаалтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулж, иргэдийн мониторингийн 3 удаагийн давтамжтайгаар хийсэн.

Түүнчлэн Баян-Өлгий, Дундговь, Говьсүмбэр аймгууд өөрийн санаачлагаар “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-аар тусгайлан сургалт зохион байгуулсан байна.

Дундговь аймгийн Тамгын газар ажилтнуудаасаа хуулийн шалгалтыг улирал тутам тестээр авч, аль хуулийн заалтыг илүү мэдэхгүй байгааг дүгнээд, тухайн хуулиудаар сургалт явуулдаг туршлага хэвшсэн.

Сүүлийн шалгалтын дүнгээр

- ▶ Үндсэн хуулийн тухай мэдлэг: 46.3%
- ▶ Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль: 50.7%
- ▶ Төрийн албаны тухай хууль
- ▶ Хөдөрмөрийн тухай хууль: 60%
- ▶ МИТБТАЭТХ-30.7%

Тухайн авсан шалгалтын асуултад энэ хуулийн тухай 4 асуулт байсан:


- ▶ Мэдээллийг хүсэгч, мэдээлэл авахдаа ямар үүрэг хүлээх вэ ?
- ▶ Аль нь уг хуулийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага биш вэ ?

- ▶ Эрхийг нь зөрчсөн тохиолдолд хаана гомдол гаргах вэ ?
- ▶ Мэдээлэл тухайн байгууллалагад хариалагдахгүй бол бусад байгууллагад ямар хугацаанд шилжүүлэх вэ?

АТГ-ын мэдээлэл, 2014 он

Дээрх шалгалтын асуулгад ажилчдын энэ хуулийн тухай мэдлэг хамгийн бага байсан /30,7 хувь/ тул МИТБМАЭ-ийн тухай хуулиар 2014 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр сургалт хийсэн сайн туршлага байна.

Бусад байгууллагын тухайд авлига, ашиг сонирхлын зөрчил, өргөдөл гомдол шийдвэрлэх, бүртгэх, өргөдөл, гомдлын бүртгэлийг цахим хэлбэрт оруулах, албан бичгийн стандарт зэрэг сэдэвт сургалт хийжээ



## МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Мэдээлэл нь хүртээмжтэй, энгийн ойлгомжтой байх ёстой. Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөө нь эрүүл саруул хүнээр хязгаарлагдахгүй, хараагүй, сонсголгүй, хэлгүй болон бусад байдлаараа хязгаарлагдмал гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй, түүнчлэн амьдралын онцлогоос хамааран төв суурин газраас алслагдмал хүмүүст ч хүртээмжтэй, тэдний онцлогт тохируулан бэлтгэгдсэн байх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл бичиг үсэг тайлагдаагүй иргэн хандахад мэдээлэл өгөхөд бэлэн байдал хангалттай байгаа эсэхийг судлахад, бүх байгууллагад ийм тусгай бодлого байхгүй байв. "Жилд нэг, хоёр удаа ийм тохиолдол гардаг ч, ийм хүмүүс ганцаараа хандсан тохиолдол бараг байхгүй, заавал гэр бүлийн нэг гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч зэрэг хүнтэй ирдэг" гэсэн нийтлэг хариултыг өгсөн.

Хараагүй хүмүүст зориулсан барел үсгийн, бичиг үсэггүй хүнд зориулсан тайлбар хөтөч, заавар зэрэг байхгүй байна.

Судалгаанд хамрагдсан 16 байгууллагаас ганцхан Нийслэлийн өмчийн харилцааны газрын удирдах албан тушаалтан ярилцлагадаа "...өнгөрсөн жил хэлгүй, дүлий хүн өргөдөл барьж ирсэн. Гэхдээ бичиг үсэгтэй хүн байсан учраас бичгээр ойлголцож, асуудлыг шийдвэрлэсэн тохиолдол бий. Бичиг үсэггүй иргэн ирсэн тохиолдолд хурууны хээ болон бусад байдлаар баримтжуулах ямар нэгэн хэлбэр, эрх зүйн зохицуулалт байхгүй" гэсэн нь цаашид бодлогын түвшинд анхаарах шаардлагатай асуудал юм.

## ТӨСӨВТЭЙ БАЙХ

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийн нэг нь түүнд зориулсан тусгайлсан төсөв хөрөнгө хуваарилсан эсэхээр хэмжигддэг.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас МИТБМАЭ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсвийг тусгайлан баталсан байгууллага байхгүй.

Харин мэдээлэл сурталчилгаа, бичиг хэрэг, сургалт, эсвэл "Нээлттэй хаалганы өдөрлөг" зэрэг төсөвтөө багтаан шийдвэрлэдэг тухай албан тушаалтнууд ярилцлагын үед танилцуулсан. Гол төлөв телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, самбар гаргах, цахим хуудас ажиллуулах, шинэчлэх зэрэгт тодорхой төсөв гаргаж ажилладаг байна. Үүнээс хамгийн их мөнгө зарцуулсан нь Өмнөговь аймаг телевизүүдтэй 48 838 000 төгрөгийн гэрээ хийж, ажилласан байна /2014 онд/.

Иргэн, хуулийн этгээдээс ирсэн хүсэлтэд хариу өгөхөд албан ёсны төсөв байхгүй ч, үйл ажиллагааг дэмжих үүднээс доорх зардлуудыг 2014 онд гаргасан байна. Үүнд:

- ✓ Баян-Өлгий аймаг – Цахимаар, утсаар санал хүсэлт хүлээн авч тэмдэглэл хөтөлдөг хоёр хүний цалин (сард нийлээд 833 042 төгрөг)
- ✓ Баянхонгор аймгийн ИТХ - Бланкны зардал 1500000 төгрөг
- ✓ Хэнтий, Дорноговь аймаг - Утасны төлбөр
- ✓ Өмнөговь аймаг – Шуудан холбооны зардал 315 000 төгрөг, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай 48 838 000 төгрөгний гэрээ хийсэн.
- ✓ Говь-Алтай аймгийн ЗДТГ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай 2 500 000 төгрөгийн гэрээ хийсэн.
- ✓ Төв аймаг – Иргэний танхимын менежер, 3 гэрээт ажилтан. Гэрээт ажилтны цалин сард 400000 төгрөгөөр төсөвлөжээ.

Мэдээллийн ажилтантай байх, түүнийг цалин хөлс, урамшууллыг тогтоох, ажилтнуудаа сургах, дадлагажуулах, байгууллагын мэдээллээ системчлэх, эмхэлж цэгцлэх, нийтэд түгээх, хүсэлтэд хариу өгөх болон бусад холбогдох зардлыг байгууллагын төсөвт тусгайлан тусгаж, баталснаар мэдээлэл ил тод, нээлттэй байх боломж бүрддэг. Хэрэв ийм төсөв хөрөнгө байхгүй, эсвэл байгууллагын аль нэг зардалд оруулан тусгах нь тохиромжтой биш ба хууль хэрэгжихэд саад болж байна.

## МЭДЭЭЛЭЛ АВАХААР ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТӨЛӨХ ТӨЛБӨР

Мэдээлэл авах эрхийг хангах, мэдээлэл хүсэгчийн эрхийг хязгаарлахгүйн тул төлбөртэй мэдээлэл өгөхийг хориглодог. Харин мэдээллийг өгөхтэй холбогдон гарах шууд, бодит зардлыг нөхөн төлүүлж болохыг хүлээн зөвшөөрдөг.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 16 дугаар зүйлд үйлчилгээний хөлс төлөх ерөнхий зохицуулалтыг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 54-р тогтоолоор баталсан “Мэдээлэл өгөх үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх чөлөөлөх журам”-аар үйлчилгээний жишиг хэмээг тогтоож өгсөн. Мөн үүнийг тухайн байгууллага зах зээлийн үнийн өөрчлөлттэй уялдуулан өөрчлөн тогтоож болно. Үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах, хэвлэх, хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй гэж заасан.

Дээрх хуулийн үндэслэлээр төлбөр авсан, төлбөрийн хэмжээг гаргасан тохиолдол байхгүй. Харин архив болон статистикийн газраас лавлагаа мэдээлэл авахад төлөх төлбөрт үйлчилгээний жагсаалтыг гаргасан тохиолдол байна. Тухайлбал, аймгуудад Засгийн газрын 2003 оны 205 тоот тогтоолын дагуу газрын архивын лавлагаа 1000 төгрөг, захирамжийн хуулбар 200 төгрөг, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам” гэх мэт төлбөр, хураамжийг бусад журмууд үйлчилж байна.

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын 1.3 дахь хэсэгт “Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх” заалтыг удирдлага болгодог ба ярилцлагын үеэр асуумжид 100 хувь хэвлэх хувилах үйлчилгээний төлбөр ч авдаггүй гэж хариулт өгсөн.

## ЦАХИМ ХУУДСААР МЭДЭЭЛЭЛ ХҮСЭХ БОЛОМЖ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан байгууллагуудын цахим хуудас дахь иргэдтэй холбогдох хэсгийг мөн тандан судлав.

УИХ-ын Тамгын газрын цахим хуудсанд санал хүсэлт гэсэн цонх байх ба энэ

цонхоор УИХ-ын дарга гишүүд, УИХТГ-ын ЕНБД зэрэгт шууд хандан хүсэлт, саналаа гаргах боломжтой байхаар хийгдсэн. Хэн, ямар мэйл хаягаар, хэзээ санал хүсэлт илгээсэн тухай тухай мэдээлэл нь ил харагддаг. Гэхдээ вэбсайтын англи хувилбар дээр энэ цонхоо comment гэж хөрвүүлсэн нь нэг анхаарал татсан. Тэгэхээр энэ нь request мөн үү? Хандсан хүмүүсийн бичвэрийг үзэхэд мэдээлэл хүссэн агуулга үүнд орсон байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын цахим хуудсанд санал хүсэлтийн тусгай цэс байхгүй, холбоо барих гэсэн цэсээр дамжин захидал хүсэлтээ илгээх боломжтой байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны цахим хуудсанд зөвхөн харилцах хаягийг бичсэн. Өөрөөр иргэдтэй харьцдаг, мэдээлэл солилцох суваг байхгүй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсанд санал хүсэлт гэсэн менюгээр орж, мэдээлэл хүсэх боломжтой байна.

УДШ, шүүхүүдийн цахим хуудсанд холбоо барих хаяг, ажилтантай холбогдох утас, э-мэйл хаяг зэргийг оруулах нь нийтлэг байна. Иргэд хүсэлт илгээх тусгай цэс байхгүй байна.

Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн цахим хуудсанд дэвшилттэй хэдэн холбоос байна. Тухайлбал, захиргааны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг ил тод болгосон. Ажлын цагаар онлайн туслах ажиллуулдаг. Мэдээлэл авах онлайн маягтыг бөглөж, мэйл явуулах цонхтой. Мөн шүүхийн мэдээлэл лавлагааны ажиллах журам, иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг ил болгосон. Түүнчлэн ажилтнуудынхаа ажлын байрны тодорхойлолтуудыг нээлттэй зарласнаараа бусад төрийн байгууллагын цахим хуудаснаас өвөрмөц ялгаатай байна.

Иргэдий төлөөлөгчдийн хурлын нэгдсэн цахим хуудас [www.khural.mn](http://www.khural.mn) ажиллаж байна. Үүнд бүх аймаг, дүүргийн ИТХ-ууд энэ нэгдсэн цахим хуудсаар мэдээллээ түгээдэг ба бүртгүүлсэн тохиолдолд тус цахим хуудсанд мэдээ орсон аймаг, дүүргийн хурлын мэдээллүүд шууд мэйл хаягаар орж, шуурхай мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна.

Олон нийтийн радио телевизийн байгууллага нь [www.mnb.mn](http://www.mnb.mn) хуудас ажиллуулдаг ба Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах байгууллага болохын хувьд 4 төрлийн мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээсэн ч цахим хуудсанд энэ төрлийн меню байхгүй, зөвхөн санхүүгийн тайлангаа Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн **6 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайланг нийтэд тавьсан**



**байна.**

УИХ-ын өргөдлийн байнгын хороо нь Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хуулийн дагуу өргөдлийн хянан шийдвэрлэдэг байна. Одоо [www.urgudul.mn](http://www.urgudul.mn) цахим хуудсаар иргэдээс өргөдөл хүлээн авдаг болж байна.

*Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №2-ээс үзнэ үү.*

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД МЭДЭЭЛЭЛ АВАХ ТУСГАЙ ДУГААР

Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай Мэдээлэл лавлагааны үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч ажиллаж буй 129 байгууллагаас 18 төрийн байгууллага иргэдээс санал гомдол, мэдээлэл авах, иргэдэд мэдээлэл өгөх, зөвлөх зориулалтаар тусгай дугаар эзэмшиж, ажиллуулж (1800 угтвартай 1969, 1979, 1890, 1206, 1209, 1234, 1280, 1281, 1283, 1284, 1285, 1286, 1287, 1288, 1289, 1290, 1291, 1292, 1901) байна. Тусгай дугаарууд нь энгийн утасны тарифаар байдаг тул иргэд хандаж мэдээлэл авах боломж бүрдсэн.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Иргэн хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн үндэсний комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно”, 17.2 дахь хэсэгт гомдлыг дээрх байгууллагууд хянан шийдвэрлэхдээ баримтлах хуулиудыг тусгайлан зааж өгсөн.

МИТБМАЭТ хуулийн 25 дугаар зүйлд мэдээлэл авах хүсэлт гаргасан иргэний эрхийг зөрчиж мэдээлэл өгөөгүй албан тушаалтныг зөрчлийн шинж байдлыг харгалзан Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын арга хэмжээ авах, төрийн албанаас халах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хуульчилсан нь мэдээлэл хүсэгчийн эрхийг баталгаажуулж, нөгөө талаар хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтаны хариуцлагыг нэмэгдүүлж, давж заалдах механизмыг бүрдүүлж өгсөн хэдий ч, хэрэгжилт ямар байгааг тандан судлах зорилго тавьсан.

### Дээд шатны байгууллага, албан тушаалтанд

Биечлэн судалсан байгууллагуудаас Дундговь аймагт дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандсан тохиолдол бүртгэгдсэн байна. 2013 онд нэг иргэн газартай авахаар хөөцөлдөж, “сул газар байгаа эсэхийг үзэхээр кадастрын зураг үзэх” гэсэн хүсэлт тавиад авч чадаагүй тул аймгийн ИТХ-ын даргад хандсан. Тухайн үед ажлыг хариуцсан мэргэжилтэн дикретээ авсан тул аймгийн кадастрын албатай холбогдож, мэдээллийг нь авч өгсөн байна.

Давж заалдах гомдол ирсэн эсэх тухай мэдээллийг албан ёсоор авахаар Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүх, Хүний эрхийн Үндэсний комисст албан бичгээр хандсан. Дээрх байгууллагууд хуулийн хугацаанд буюу 7 хоногийн дотор судалгаа мэдээллийг гаргах, хариу ирүүлснийг тэмдэглэх нь зүйтэй.

– Захиргааны хэргийн шүүхэд /Хавсралт №3/

- ▶ 2011 онд 1 хэрэг
- ▶ 2012 онд 1 хэрэг
- ▶ 2013 онд 1 хэрэг
- ▶ 2014 онд байхгүй

Дээрх 3 хэргийн шийдвэрлэлтийн байдлыг үзвэл хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон, эсвэл зохигчид эвлэрсэн байна. Харин мэдээлэл авах хүсэлт гаргагч нь бүгд компани буюу хуулийн этгээд байна. Эдгээр компани нь бүгд нэлээд нэр хүндтэй, хуулийн зөвлөхтэй байгууллагууд байв.

Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахад нэхэмжлэлийн бүрдүүлбэр буюу бичиг баримт бүрдүүлэхээс гадна, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжид 70200 төгрөг төлж байгаа нь хөдөлмөрийн хөлсний 0,36 хувьтай тэнцэж байгаа нь энгийн мэдээлэл хүсэгч иргэний хувьд нэлээд өндөр тусч байна.

### Хүний эрхийн үндэсний комисст

Хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш тус байгууллагад мэдээлэл өгөөгүй асуудлаар мэдээлэл хүсэгч иргэн хандаагүй байна.

Энэ нь нэг талаар иргэд мэдээлэл хүсэхгүй, хүссэн ч давж заалдах тухай хангалттай ойлголтгүй байгааг харуулж байна.

Түүнчлэн хуульд мэдээллийн бие даасан комиссар байх тухай тусгаагүй, Хүний эрхийн комиссын дүгнэлт нь зөвлөмжийн чанартай тул заавал биелүүлэх шинж агуулдаггүй тул үр нөлөө багатай давж заалдах механизм болж байна.

### Мэдээлэл өгөөгүй үндэслэлээр хариуцлага тооцсон тохиолдол:

Биечлэн судалсан 16 байгууллагаас нэгд нь хариуцлага тооцсон тохиолдол байна. Анкет асуулгаар явуулсан судалгаагаар хариуцлага тооцогдсон тухай мэдээлэл ирээгүй.

Дээр дурдсан Дундговь аймгийн кейсийн эзэн буруутай албан тушаалтанд хариуцлага тооцохыг шаардсанаар, тус албан хаагчид нэг сарын цалингийн 25 хувиар бууруулах хариуцлага тооцсон байна .



Эндээс МИТБМАЭ-ийн тухай хууль сайн хэрэгжиж байгаа учраас давж заалдах гомдол гаргахгүй байна уу? эсвэл энэ механизм ажиллахгүй буюу ажиллахад төвөгтэй, чирэгдэл дарамт ажиллагаа ихтэй процедурыг бий болгож байгаагаас зайлсхийж байна уу? гэдэг хоёр талтай асуулт гарч ирж байна.

Мэдээж эхний асуултад хариулахад нэгэнт мэдээлэл хүсэх хүсэлтийн бүртгэлийн тогтолцоо байхгүйтэй холбоотойгоор тоон мэдээлэл гаргах, үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй учир дараах кейсүүдийг ишлэл болгож байна. Харин хоёр дахь асуултын хариуг цаашид иргэд, олон нийтийг өргөнөөр хамруулсан бусад судалгааны ажлын хүрээнд тодруулах, үнэлэлт өгөх шаардлагатай юм.

---

Дундговь аймагт ажилласан багийн тайлангаас

Төрийн бус байгууллагууд өөрсдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, судалгаатай холбогдуулан мэдээлэл авах хүсэлтийг төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргаж, мэдээлэл авах практик оролдлогуудыг хийж байна. Гэвч хуулийн хүрээнд мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэх, хариу өгөх нэгдмэл ойлголтгүй, хариу өгөхгүй “чимээгүй” дарах, эсвэл “хувь хүний мэдээлэл байгаа учраас өгөх боломжгүй” зэрэг халхавчилсан хариу өгсөөр байгаа юм.

**Хүсэлтэнд хариу өгдөг зураглалыг гаргана.**

**Мэдээлэл хүсэгчдэд:**

Жижүүр-----Мэдээллийн ажилтан-----Хариуцсан алба, хэлтэс /тэр дор нь/-----Мэргэжилтэн/30 хоног/----- Иргэн

**Судалгааны ажилтны хувьд: Үр дүнгийн гэрээтэй холбоотой:**

ЗДТГ дарга-----Бичиг хэргийн ажилтан-----Хяналт үнэлгээний хэлтэс-----Хэлтэс Албадын дарга нарийн бичиг-----Судлаач

Харин тэдний зүгээс шүүхэд, эсвэл дээд шатны байгууллагад давж заалдсан тухай мэдээлэл байхгүй байна.

Кейс 1.

“Ил тод байдал” сан 2014 оны 9-р сарын 22 нд БЗД-ийн ИТХ, ЗДТГ-т Мэдээлэл хүсэх тухай албан бичиг явуулсан боловч хариугаа авч чадаагүй. Мэдээлэл өгөхгүй гэж хэлээгүй болохоор дээд шатны албан тушаалтан, байгууллагад гомдол гаргаагүй.

ЗДТГ-ын Иргэдийн эрэлт, хүсэлт хариуцсан мэргэжилтэн “Манайд мэдээлэл авахаар хүсэлт гаргасан тохиолдол нэг ч байхгүй” гэж хэлсэн.

ИТХ-ын Ажлын албаны дарга Ч.Мэндсайхан “Ийм бичиг ирсэн. Их олон мэдээлэл хүссэн зарим нэг мэдээлэл нь манай сайт, мэдээллийн самбараас олоод авч болохоор мэдээлэл байсан. Тэгээд ч энэ мэдээллийнхээ хариуг хэзээ авахаа албан бичигтээ бичээгүй, албан бичгийн стандарт хангаагүй байсан.” гэж мэдээллийн хариуг одоо болтол өгөөгүй байгаа шалтгаанаа тайлбарлав.

### Кейс 2.

“Глоб Интернэшнл төв” ТББ-аас 2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Мэдээлэл сурталчилгааны төсөв, түүний зарцуулалтын талаарх мэдээллийг авахаар Сангийн яаманд 3 хүсэлт, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийгслэлийн ЗДТГ, ИТХ, бусад 8 яаманд хандаж хүсэлт явуулсан. Ийнхүү нийт 14 төрлийн мэдээлэл хүссэнээс 4 байгууллага хүсэлтэд хариу өгөөгүй. Үүнд, БШУЯ, ХАХНХЯ, ҮХХЯ болон Харилцаа холбооны зохицуулах хороо.

### Кейс 3.

Ил тод байдал сангаас 2014 онд 3 удаагийн давтамжтайгаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Монгол улсын яамд, агентлагын ил тод байдлыг үнэлгээний индексээр судалсан байна. Тус судалгааны хамгийн сүүлийн шат нь 2014 оны 8 дугаар сард авсан мэдээллээр хийсэн индексийн мэдээлэлд анализ хийж үзэв.

Тус индекс нь нийт 31 асуулттай, асуулт бүрийг 1-5 оноогоор /5 хамгийн сайн/ үнэлсэн ба хамгийн сүүлийн үзүүлэлт нь “Мэдээлэл хүссэн албан бичигт хариулсан байдал” мэдээлэл хүссэн албан бичиг 2 удаа явуулж, түүнд хариулсан байдлаар нь үнэлгээ өгчээ.

ЗГХЭГ, 16 яам, нийт 17 байгууллагаар үзэхэд хангалттай мэдээлэл, хариу өгсөн байгууллага байхгүй, дундаж үзүүлэлтээр 1,7 оноо буюу хангалтгүй хариу өгсөн байна. Огт хариу ирүүлээгүй 2 яам, ЗГХЭГ байна.

Агентлагуудын хувьд 24 байгууллагыг хамруулснаас 1,6 оноо авсан. Огт хариу ирүүлээгүй байгууллага 6 байна.

Дүгнэвэл, яамд, агентлагууд нь албан бичигт хариу өгдөг соёл хэвшээгүй, хариу өгвөл татгалзсан, хэт ерөнхий, эсвэл ямар ч хариу өгөхгүй байх хандлага давамгайлж байна.

#### Кейс 4.

Глоб Интернэшнл Төвөөс УДШ-ийн Ерөнхий шүүгчид хандан “УИХ-ын 2012 оны сонгуульд оролцсон 15 намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг, тэдгээрт сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт 2014 оны 11 дүгээр сарын 21-нээс өмнө гаргаж өгнө үү” гэсэн албан бичгийг 2014 оны 11 дүгээр сарын 17-ний өдөр №160 албан бичгээр хүсэлт тавьсан. Үүнд УДШ-ийн Тамгын газраас 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 5-2830 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн. Тус “Хүсэлтийн хариу” бичигт “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Бүртгэлийн байгууллага нь иргэний үнэмлэхийн, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын болон татвар төлөгчийн бүртгэлийн дугаартай холбогдох мэдээллийг хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, этгээдэд өгч болно” гэж заасан тул таны хүсэлтийг хүлээн авах боломжгүй байгааг уламжилъя” гэжээ.

Энэ албан бичгээс дүгнэвэл: хугацааны хувьд хуулийн хугацаандаа буюу 7 хонгтоо багтаан хариу өгсөн байна. Харин хүсэлтийг хүлээн авч, мэдээлэл өгөхгүй байгаа үндэслэл болсон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт чухам яагаад хараарч буй талаар дэлгэрэнгүй тайлбар шаардлагатай байсан. Тухайлбал:

1. Тус мэдээлэл ямар үндэслэл, тайлбар, тодорхойлолтоор иргэний үнэмлэхийн, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын ... холбогдох мэдээлэлд хараарч буй,
  2. сонгуульд оролцож буй бүх намууд сонгуулийн үеэр мөрий хөтөлбөрөө ил зарладаг хэдий ч, улсын бүртгэлд бүртгүүлсэн хувь нь яагаад нээлттэй биш мэдээлэлд хамаарч байгаа,
  3. хуулиар тусгайлан эрх олгосон байгууллага, этгээдэд өгч болно гэж ямар хууль, ямар байгууллага, албан тушаалтан бэ? гэдэг нь ерөнхий, тодорхой бус байна. Мөн “өгөхгүй ч байж болно” гэсэн давхар санааг агуулсан, хоёрдмол утгатай байгаа
- Иймд “Глоб Интернэшнл төв” ТББ-аас дахин дэлгэрэнгүй тайлбар хүссэн хүсэлтийг УДШ-д явуулсан ч хариуг хуулийн хугацаанд буюу 7 хоногтоо багтаан аваагүй байна.

Кейс 5.

Хан-уул дүүргийн Өлзийт хорооны Засаг дарга Батсуурь иргэнд мэдээлэл өгөхөөс татгалзсан:

Асуудал нь: Өлзийт хороололд хашааны хаягийн тодорхойлолт авахаар очих, уулзах бүрт өөр өөр тайлбар хэлж буцааж, чирэгдүүлсэн.

1. Газрын байцаагчаас кадастрын зураг дээр хаягийн тодорхойлолт хийхийг зөвшөөрсөн цохолт хийлгээд ирэхээр өгнө.

2. Хүссэн цохолтыг хийлгээд очиход хашаа бүрэн бүтэн биш, хаалга, цоож, цуургагүй бол хаягийн тодорхойлолт өгч болохгүй гэсэн. Нийслэлийн засаг даргын захирамж гарсан, тодорхойлолт өгөхгүй гэв.

А. Та үндэслэл болгож байгаа захирамж, бичиг баримтаа үзүүлээч гэсэн хүсэлтийг амаар тавьсан.

- “Чамд өгөхгүй. Яваад заргалд, өрөөнөөс гар” гэсэн хариу өгөв.

### Хүндрэл бэрхшээл бэрхшээл

Энэхүү судалгааны ажил нь өөрөө мэдээлэл хүсэх, хуулийн 23 дугаар зүйлийг турших боломжийг давхар олгосноороо онцлог юм. Судалгаанд хамрагдсан байгууллагууд харьцангуй эерэг хандлагатай байсан ч, цөөн хэдэн байгууллага судалгааны багийг хардах, мэдээлэл ямар зорилгоор авах гэж байгааг асуух, байгууллагын ажлын үнэмлэх шаардах, мэдээллээ нууцлах зэргээр бэрхшээл тулгарч байв. Тухайлбал, Баянзүрх дүүргийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга З.Үүрцайх, захиргаа, хяналтын албаны дарга С.Отгончулуун болон бичиг хэрэг дотоод ажил хариуцсан ажилтан, санхүүгийн ажилтан зэрэг нь судалгааны мэдээлэл өгөхөөс аль болох зайлсхийж байсан. Багийн гишүүд 2 албан бичиг, нэрийн хуудастай, 3 удаагийн оролдлогоор ярилцлагын судалгаа хийсэн ч баримтжуулалт хийж чадаагүй, бичгэн хэлбэрээр тухайн байгууллагын төлөвлөгөө, тайланг олж авч чадаагүй болно. Ярилцлагын хэсгээс товч сийрүүлбэл:



Баянзүрх дүүргийн халамж, үйлчилгээний хэлтэс

2014 оны 12 сарын 01 өдөр

Судалгааны багийн гишүүн нь өөрийн төрийн бус байгууллагын албан бичигтэйгээр мэдээлэл хүссэн. “Хэдийгээр иргэдээс ирсэн санал хүсэлтийг хүлээн авч хариу өгдөг” гэсэн боловч тухайн нөхцөлд хүсэлт болон мэдээлэл авч байгаа талаар ямар нэг тэмдэглэгээ хийгээгүй.

Иргэдээс ирсэн хүсэлтийг хөтөлдөг тусгай дэвтэр байдаггүй, санал гомдлын дэвтэртээ хавсарган бүртгэдэг. Утсаар ирсэн хүсэлтийг БЗД-ийн НХҮХ-н мэргэжилтнүүдийн 451360 утсанд жижүүрлэсэн бүртгэлд бүртгэдэг. Нэг цэгийн үйлчилгээнээс хэрэгцээтэй мэдээлэл авдаг. Мэдээлэл авахад ямар нэг төлбөр хураамж авдаггүй. Мэдээллийн нээлттэй байдалд зориулсан тусгайлсан төсөв байдаггүй, шуудан холбооны зардал гэдэгт хамааруулдаг. Энэ ярианы дундуур Баянзүрх дүүргийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга З.Үүрцайх “Глоб Интернешнл Төв” ТББ байгууллагын судалгаа хийх албан тооттой танилцсан. Тухайн судалгааг өгөхөд хүндрэлтэй зарим нэг дотоод санхүүжилтийн нарийн мэдээлэл, мөн судалгаанд заавал оролцох зааварчилгаа байхгүй тул энэ талаар ярилцажшийднэ гэсэн хариуг өгсөн учраас судалгааг дараа өдөр үргэлжлүүлэхэд хүрсэн.

Тус хэлтсийн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (иргэдээс ирсэн санал гомдлын асуудлыг хавсардаг) Өлзийхишигтэй уулзаж ярилцсан. Даргын зөвшөөрөлтэйгээр өргөдөл, гомдлын дэвтэртэй танилцсан ч зураг авах зөвшөөрөл өгөөгүй, тухай дэвтэрийн бүртгэлийн мэдээллийн зургийг устгахыг шаардаж устгуулж, зурган болон бусад цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхөөс татгалзсан.

2014 оны 12 сарын 02 өдөр

Захиргаа, хяналтын албаны дарга С.Отгончулуунтай дахин ирж уулзсан боловч, сарын эцэс болж тайлан тооцоо гаргах ажил ихтэй, аудитын газраас шалгалт их тул ямар нэг мэдээлэл өгөх боломжгүй. Ирэх долоо хоногийн нэг дэх өдөр буюу 12 дугаар сарын 8-ны өдөр дахин ирэхийг санал болгосон.

2014 оны 12 сарын 08 өдөр

Захиргаа, хяналтын албаны дарга С.Отгончулуунтай уулзаж, ярилцлага авсан. 2014 оны ажлын төлөвлөгөөтэй танилцахыг хүссэн ч бичгээр үзүүлээгүй.

З.Үүрцайх /Баянзүрх дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга /ярилцлагаас хэсэгчлэн авав/

А: 23, 24 хуулийн талаар. Ямар тэмдэглэгээ хийдэг вэ? 24-р зүйлд үр дүнгийн гэрээнд тусгаж өгсөн үү? Үнэлгээ хийх нь ажлын нэг шалгуур болно гэсэн байгаа. Отгончулуун даргын өөрийн гэрээний заалтыг зургаар авлаа. Таны хувьд ерөнхий менежерын хувьд үр дүнгийн гэрээнд ямар зүйл заалт багтсан бэ? Бидэнд зөвхөн мэдээллийн ил тод байдлыг хангах гэдэг заалт тусгагдсан эсэхийг судлах зорилготой.

Х: Ажлын үнэмлэх авчирч үзүүлнэ гэсэн

А: /Үзүүлэв. Дэвтэрт бидний иргэний үнэмлэхийн мэдээллийг тэмдэглэж авав/. Албан бичигтээ судалгааны багт ажиллаж буй хүмүүсийн овог нэрийг оруулж, Отгончулуун даргад өгсөн тухай хэлэв/

Х: Мэдээлэл өгөхгүй гэсэндээ биш. Төр засгийн хэмжээнд юмнууд яригдаад байна, тэрэнтэй холбоотойгоор бидэнрүү довтолох, гэнэтийн юмнууд гарах магадлал өндөр байна. Надад хардаж сэрдэх эрх нь байна.

Х: манай авсан мэдээллээ утсаар ярьсан. Ямар ч албан газар ирээд, албан бичигтэй ирээд албан бичгийнхээ хүрээнд хариугаа авах ёстой. Манай мэдээллийг хагас дутуу сонсоод хаашаа ч мэдээлээд байгаан. Утсаар шууд яриад байсан нь таалагдаагүй.

А: Лавлаж асуух зүйл байсан. Судалгааны арга зүйн хувьд багийн бусад гишүүдээс асуух зүйл байсан.

Х: Та хоёр ямар зорилготой яваад, ямар мэдээлэл аваад, хаашаа яаж цацах гэж байгааг нь бүрхэг байна.

А: Мэдээллийн ил тод байдал, УИХ тамгын газар, НҮБ-н хөгжлийн хөтөлбөртэй хамтарч хийж байгаа судалгаа. Албан бичгээр хүсэлтээ тавьсан. Заавал албан бичигтэй мрэх шаардлагагүй байсан ч, судалгааны хугацаа богино тул бичигтэй ирсэн. Төрийн аль ч байгууллага дээр очоод, төсөл төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ байгаа эсэхийг асууж болно. Үйл ажиллагаагаа түргэвчлэхийн тулд албан бичиг өгсөн. Мэдээлэл олж авах тухай эрхийн хуулиар иргэн хүний хувьд үзэх мэдээллүүдийг хүсч байна. Танай зүгээс дэвтэрийн хөтлөлт, дэвтэр дээрээс ямар хүсэлтийн түүвэр хийе гэсэн. Бидний хүссэн зүйл гэвэл танай байгууллагаас ямар төрлийн мэдээлэл хүсч байгаа вэ гэдэг үзэх... Отгончулуун даргын хэлснээр мэдээлэл авахаар бичгээр хүсэлт ирж байгаагүй гэсэн. Таны хувьд нэмэлт тайлбар хийх үү?

Х: Иргэд манайд үйлчилгээ авах зорилготой ирдэг. Тэр утгаараа үйлчилгээний холбогдолтой мэдээлэл өгөхөөс өөрөөр мэдээлэл авъя гэхэд манай вэб сайт байна, холбоотой мэдээллүүд байна. Доор самбар дээр мэдээллүүд байна. Хороо хариуцсан мэргэжилтнүүд самбар дээр байршуулдаг. Манай бүх мэдээлэл ил тод байгаа учраас иргэд ийм мэдээлэл авах гэж ирдэг. Түүнээс биш өөр ямар мэдээлэл авч болох вэ... тодорхой ш дээ...

А: Бид иргэн хүний хувьд ч мэдээлэл авах эрхтэй. Албан бичгээр хандлаа, мэдээлэлтэй биет байдлаар танилцуулсангүй. Цаасан хэлбэрээр, биет баригдах мэдээлэлгүй байна. Төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ, түүний үнэлгээ тайлангийн талаарх мэдээлэл авмаар байна.

Х: Албан бичгээ хийгээд ир, албан бичгээр буцаагаад явуулъя.

Бодит байдал: Вэбсайт нь ажиллахгүй ба олон нийтэд танилцуулж, google-ээр илэрч буй "Prezi" танилцуулга нь бодит байдлаас тэс өөр байсан. Баримтжуулалтыг Хавсралт №4 харна уу.

- ✓ “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-аас илүү Засгийн газрын 143-р тогтоолын талаар төрийн албан хаагчид мэдэж байна. Түүнчлэн МИТБМАЭТХ-ийн агуулгыг хуулиар заасан 4 төрлийн мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулж ил тод болгоно гэсэн өрөөсгөл ойлголттой байна.
- ✓ “Мэдээлэл” гэж юу вэ, “ил тод болгох”, “нээлттэй болгох”, “мэдээлэл авах хүсэлт” зэрэг нэр томъёоны тодорхойлолт байхгүйгээс ойлголтын зөрүү их гарч байна.
- ✓ Иргэн, хуулийн этгээдийн зүгээс албан тушаалтан болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн захиргааны байгууллагад хандах хэрэгцээ шаардлага харилцан адилгүй байна. Ялангуяа үйлчилгээний байгууллага, нэгжид ихэвчлэн үйлчилгээ хүсэх хүсэлт гаргадаг. Үүнийг нь өргөдөл гомдлын, эсвэл ирсэн явсан бичгийн бүртгэлд хөтөлдөг. Энэ дунд хуулиар ил тод байна гэж заасан 4 төрлийн мэдээлэлтэй холбоотой хүсэлт холилдож бүртгэгддэг.
- ✓ Энэхүү хуулийн 23 дугаар зүйлийн дагуу төрийн байгууллагууд болон хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах байгууллагууд нь иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах тухай хүсэлтийг амаар, бичгээр, цахимаар хүлээн авч, бүртгэл хөтлөх, хугацаанд нь мэдээлэл өгөх үүрэг хүлээсэн. Судалгааны явцад ганцхан Баянхонгор аймгийн ИТХ “Мэдээлэл хүсэгчийн бүртгэл” гэсэн дэвтэртэй байсан. Харамсалтай нь мэдээлэл хүссэн хүсэлт, үйлчилгээ хүссэн хүсэлттэй холилдож бүртгэгдсэнээс нэгдсэн тоон болон чанарын үзүүлэлт гаргах боломжгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг шалгах зорилгод нийцэхгүй байна.
- ✓ Шийдвэрлэх хугацааны хувьд өргөдөл гомдлын хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу 30 хоногийн дотор шийдвэрлэн хариу өгч байгаа нь МИТБМАЭТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалт “хариуг шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариу өгөх”, 14.8 дахь заалт “ажлын 7 өдрийн дотор” хоногоор тооцвол 9 хоногийн дотор бүрэн мэдээлэлтэй болох мэдээлэл хүсэгчийн эрхийг зөрчиж байна.
- ✓ Төрийн байгууллагын нэгдсэн мэдээллийн системийн ангилал, албан хаагчид хоорондын мэдээлэл солилцоо болон хяналтын тогтолцоо системтэй бүрдээгүй. Энэ нь мэдээлэл хүсэгч хүсэлтийн хариугаа нэн дариу авах, хугацаанд нь авахад хүндрэл үүсгэх, даргаас эхлээд бүхий л албан тушаалнуудыг дамжих, эсвэл даргаар заавал цохолт хийлгэж, хуваарилуулсны дараа боловсруулалт хийж, мэдээлэл өгч байгаа явц нь шуурхай үйлчлэх төрийн үйлчилгээний зарчмыг алдагдуулж, шат дамжлага ихтэй, хүндрэл чирэгдэл бий болгож байна.
- ✓ Амаар болон цахимаар гаргасан хүсэлтийг бүртгэж, тэмдэглэл хөтөлж байгаа сайн туршлага байгаа ч, ил тод байдал нь хангалтгүй байна. Тухайлбал Баянзүрх дүүргийн халамж үйлчилгээний мэргэжилтнүүд нь ажлын утсан дээрээ ээлжлэн

жижүүрлэж, бүртгэл хөтөлдөг, Дорноговь аймгийн 70520003 утсанд ирсэн мэдээллийг тэмдэглэх тусгай маягттай, түүнийгээ бүртгэдэг.

✓ Мэдээллийн ажилтан гэж тусдаа орон тоо байхгүй. Иргэд, хуулийн этгээдээс ирсэн хүсэлтийг иргэдийг хүлээн авах төвийн ажилтан, тусгай дугаарын оператор, өргөдөл гомдол, бичиг хэргийн ажилтан болон түүнтэй төсөөтэй ажил үүргийн хуваарьтай албан хаагч гүйцэтгэж байгаа нь байгууллагад хөтлөгддөг бүхий л төрлийн бичиг баримттай холилдож, бүртгэгдэн, эмх цэгцгүй болж, хяналт тавих, хариуцлага тооцох бодит үндэслэл болохгүй.

✓ Судалгаанд хамрагдсан 64 байгууллагаас 42 нь үр дүнгийн гэрээндээ мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгаж өгсөн. Гэвч 4 төрлийн мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулсан байдал, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тоон үзүүлэлтээр хязгаарласан хэмжиж байна. Үнэлэх хамгийн гол үзүүлэлт болох иргэдэд мэдээлэл авах эрхийг таниулан сурталчлах, төлөвлөгөө, заавар, удирдамж баталж, түүний мөрөөр иргэдийн идэвхтэй оролцоог хангах ажил орхигдсон байна.

✓ Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагаас 73% нь дотооддоо авлига, ашиг сонирхлын зөрчил, өргөдөл гомдол шийдвэрлэх, бүртгэх, өргөдөл, гомдлын бүртгэлийг цахим хэлбэрт оруулах, албан бичгийн стандарт зэрэг сургалт зохион байгуулсан. Үүнээс гурав нь (Баян-Өлгий, Дундговь, Говьсүмбэр) Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар сургалт хийсэн байна. Харин бидний судалж буй хуулийн 23, 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх талаар хийсэн сургалт, хэрэгжүүлсэн туршлага хангалтгүй. Хуулийн талаар иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа огт байхгүй.

### 1. Мэдээлэл авах хүсэлт бүрийг бүртгэдэг тусгай тэмдэглэл, хяналтын тогтолцоог бий болгох

Мэдээлэл хүссэн хүсэлтийг тусгайлан бүртгэж, хянадаг тогтолцоо бий болгосноор иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг хангах, эрхийг зөрчсөн тохиолдолд буруутай албан тушаалтанд хуулийн хариуцлага хүлээлгэх нөхцөл боломж бүрдэнэ. Мөн төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд хуулийн 23, 24 дүгээр зүйлээр тусгайлан сургалт явуулах, хууль хэрэглээний эрэмбийг таниулах шаардлагатай байна. Хуулийн хэрэглээний эрэмбийг мэдэхгүйгээс хуучин шинэ хуулиудын зөрчил, хийдэл, давхардлыг өөрсдийн мэддэгээр тайлбарлан хэрэглэх нь түгээмэл байна. Иймд эрх зүйн хэм хэмжээний актууд, түүнд тавигдах шаардлага, хууль ёсыг сахиулах, хууль биелүүлж, иргэний үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангахад бүхий л талуудын хүчин чармайлт, хамтын ажиллагаа хэрэгтэй байна.

### 2. Мэдээллийн ажилтантай, түүнд зориулсан гарын авлага, заавар, стандартуудтай болох

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж, хуульд заасан 4 төрлийн мэдээллээ ил тод, нээлттэй, шуурхай хүргэхийн тулд мэдээллийн ажилтныг орон тооны, эсвэл хавсран гүйцэтгэхээр тусгайлан ажиллуулах нь зүйтэй байна. Мэдээлэл өгөх үүрэг хүлээсэн ажилтантай, түүнд зориулсан сургалт, арга зүй, гарын авлага-хөтөч, стандартай, бүртгэл тэмдэглэгээ хөтлөх нэгдсэн зааврыг төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт нэмж оруулах шаардлагатай байна. Ингэснээр хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын мэдээлэл системчлэгдэх, мэдээлэл хүссэн иргэн, хуулийн этгээдэд хугацаа алдахгүй, шат дамжлагагүйгээр мэдээлэл хүрдэг болох, иргэдийн итгэл үнэмшил, оролцоо, хяналт сайжрахад чухал үр нөлөөтэй болно.

### 3. Мэдээлэл цэгцтэй системчлэгдсэн, шинэчлэгдэж байх

Мэдээлэл өгөх ажилтанд холбогдох асуудлыг хариуцсан албан хаагчид нь өөрийн эрхэлсэн ажил үүрэгтэй холбоотойгоор гарах бүхий л мэдээллийг хуулийн хугацаанд нь гаргаж, тухай бүр өгч, нэгдсэн мэдээллийн сан үүсгэдэг, мэдээллийн ажилтанг мэдээллээр хангах чиг үүргийг тухайн байгууллагын ажилтан бүрийн ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон бусад гэрээнд тусгадаг, үнэлдэг болгох нь мэдээллийн шинэчлэлт, цаг үеийн байх зэрэг шаардлагад нийцнэ. Тухайлбал, санхүү хариуцсан ажилтан санхүүгийн тайлан, орлого зардлын гүйлгээ зэргээ Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татварын ерөнхий хуулийн холбогдох зүйлд заасан хугацаанд тайлан балансаа гарсан даруй мэдээллийн ажилтанд хүлээлгэн өгөх боломжтой.

### 4. Үр дүнгийн гэрээний заалтыг нарийвчлах, гол шалгуур болгон иргэдийн оролцоотой үнэлдэг болох

Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах гэсэн ерөнхий нэр томъёогоор тусгахаас зайлсхийж, ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэдэд хүрч үйлчлэх ажлыг төлөвлөх, удирдах, зохион байгуулах, хэрэгжилтийг хангахаар тусгаж, хагас, бүтэн жилийн үнэлгээний тайлангаа иргэдийн оролцоотойгоор дүгнэдэг болгох.

## **5. Хэрэгцээтэй, ач холбогдол бүхий мэдээллийг эрэмбэлж, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх**

Үр дүнтэй эргэх холбоог бий болгохын тулд иргэдийн дунд хэрэгцээт мэдээллийн судалгаа явуулж, иргэдэд мэдээлэл өгөх төлөвлөгөө боловсруулах, зааварчилгаа, зөвлөмж боловсруулах, иргэдэд зориулсан хэвлэл мэдээллийн аян, сургалт болон бусад үр дүнтэй механизмуудыг ашиглах шаардлагатай байна. Ажлын үр дүнг хүсэлт гаргаж хандсан иргэн, хуулийн этгээдийн тоо, мэдээллээр хангасан чанарын үзүүлэлтийг гол шалгуур болгон тайлагнадаг болговол иргэн, албан тушаалтан хоорондын харилцаа ойртож, төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн хүссэн стандарт мэдээллээр “булах” бус, харин хувь иргэнд хэрэгтэй, сонирхол татсан, анхаарал татсан мэдээллийг нээлттэй болгох соёл хандлагыг төлөвшүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

## **6. Цахимаар мэдээлэл хүсэх нэгдсэн стандарттай болох, хянан шийдвэрлэх процедурыг ил тод болгох**

Цахимаар, эсвэл тусгайлсан маягтаар мэдээлэл хүссэн хүсэлтийг бүртгэхдээ мэдээлэл авах үндэслэл, хэрэгцээг асуухгүй байх тухай хуулийн 12 дугаар зүйлийг баримталж, сайн туршлагуудыг түүвэрлэн жишиг болгож, цахим хуудсаар мэдээлэл авах боломж, түүний эргэх холбоог бий болгох нэгдсэн стандарт бий болгох шаардлагатай. Тухайлбал, мэдээлэл авах хүсэлт илгээх цонхыг ажиллуулахдаа, хүлээн авсан эсэх, хянан шийдвэрлэсэн эсэх, хэзээ хариу өгөх зэрэг үе шат бүрийн процессыг ил харуулж, хариугаа хүлээн авсан бол тухайн иргэн, хуулийн этгээд үнэлгээ өгдөг, хангалтгүй гэвэл давж заалдах, гомдол гаргах механизмуудыг бүрдүүлсэн цахим системийг бий болгох боломж байна.

## **7. Хууль хэрэгжүүлэх тусгай төсөвтэй байх**

Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх болон бусад хэлбэрээр иргэн, хуулийн этгээдтэй харьцах тусгайлсан төлөвлөгөө, удирдамж баталж, мэдээллийн ажилтан, түүний орон тоо, иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх, түүнтэй холбоотой бусад зардлыг нарийвчлан тооцож, төсвийг жил бүрийн төсөвтөө оруулж батлах, хуулийг хэрэгжүүлэх, таниулахад зарцуулах, хяналт тавих үнэлгээний нэгдсэн стандарттай болох хэрэгтэй байна.

## 8. Хариуцлагын механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Хуулийн үйлчлэл хамаарах байгууллагууд иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, албан бичигт хариу өгдөг соёлыг төлөвшүүлэхийн тулд шийдвэрлэсэн ба шийдвэрлээгүй хүсэлтэд тоон ба чанарын анализ хийж, хугацаа хоцроосон, хариу өгөөгүй албан тушаалтан, удирдлага хоёуланд нь хариуцлага хүлээлгэдэг болгох. Хэрэв зөвхөн албан хаагчид арга хэмжээ авдаг болвол удирдах албан тушаалтны хариуцлагагүй байдал, мөн хариуцлагаас өөрийгөө зайлуулах, хяналтаас гарах эрсдлийг бий болгож болзошгүй юм.